Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Урсгал зардал	26,237.5 26,237.5
2	Монгол Улсын Их Хурлын дарга Урсгал зардал	66,107.0 66,107.0
3	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Урсгал зардал	3,345.1 3,345.1
4	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Урсгал зардал	11,114.0 11,114.0
5	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Урсгал зардал	90,597.1 90,597.1
6	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Урсгал зардал	4,480.5 4,480.5
7	Улсын ерөнхий прокурор Урсгал зардал Хөрөнгийн зардал	67,938.7 54,844.8 13,093.9
8	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Урсгал зардал	15,084.0 15,084.0
9	Монгол Улсын Ерөнхий аудитор Урсгал зардал	26,567.1 26,567.1
10	Авлигатай тэмцэх газрын дарга Урсгал зардал	33,129.6 33,129.6
11	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	10,928.0 10,470.0 458.0
12	Төрийн албаны зөвлөлийн дарга Урсгал зардал	3,507.7 3,507.7
13	Үндэсний статистикийн хорооны дарга Урсгал зардал	18,984.2 18,984.2
14	Сонгуулийн ерөнхий хорооны дарга Урсгал зардал	4,234.6 4,234.6
15	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дарга Урсгал зардал	15,101.3 15,101.3
16	Монгол Улсын Ерөнхий сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	237,031.4 205,020.3 32,011.1
17	Монгол Улсын Шадар сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	182,230.6 157,307.0 24,923.5

18	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	337,839.4 15,055.2 322,784.2
19	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	77,897.5 54,806.4 23,091.1
20	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	125,848.1 107,356.0 18,492.1
21	Гадаад харилцааны сайд Урсгал зардал	154,609.2 154,609.2
22	Сангийн сайд Урсгал зардал үүнээс: Зээлийн хүүгийн төлбөрт Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	4,065,076.1 2,024,674.1 1,180,634.6 245,402.0 1,795,000.0
23	Хууль зүй, дотоод хэргийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	779,385.9 737,828.2 41,557.7
24	Зам, тээврийн хөгжлийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	480,244.1 14,949.0 465,295.1
25	Батлан хамгаалахын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	312,267.4 298,501.7 13,765.6
26	Боловсрол, шинжлэх ухааны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	2,687,402.4 2,158,121.0 529,281.5
27	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	39,606.9 16,082.1 23,524.8
28	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	485,601.0 410,928.5 74,672.5
29	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	2,723,607.6 2,686,766.3 36,841.3
30	Эрүүл мэндийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	1,279,249.8 1,107,131.0 172,118.7
31	Эрчим хүчний сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	255,192.9 86,193.6 168,999.2
32	Барилга, хот байгуулалтын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	379,657.7 34,505.1 345,152.5

33	Соёлын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	268,902.7 124,665.4 144,237.3
34	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	64,645.2 43,019.2 21,625.9
35	Шүүхийн сахилгын хорооны дарга Урсгал зардал	3,217.0 3,217.0
36	Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	87,166.1 38,343.0 48,823.2
37	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Урсгал зардал	5,608.6 5,608.6
38	Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжэрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Хөрөнгийн зардал	339,743.2 339,743.2

6.2. Монгол Улсын төсвөөс 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр доор дурдсан хэмжээтэй санхүүжилт олгоно:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Барилга, хот байгуулалтын сайд	5,000.0
2	Боловсрол, шинжлэх ухааны сайд	31,820.3
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	50,000.0

Санал хураалт явуулья.

46 гишүүн дэмжиж, 6 дугаар зүйл батлагдлаа.

7 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2023 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 15,480,800.3 сая төгрөг байна.

Санал хураалт явуулья.

49 гишүүн дэмжиж, 7 дугаар зүйл батлагдлаа.

8 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 2,695,015.3 сая төгрөгөөр санхүүжүүлнэ.

Санал хураалт явуулья.

45 гишүүн дэмжиж, 8 дугаар зүйл батлагдлаа.

9 дүгээр зүйл. “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 оны төсвийн жилд 279,590.4 сая төгрөгийн эргэн төлөлт хийнэ.

Санал хураалт явуулъя.

50 гишүүн дэмжиж, 9 дүгээр зүйл батлагдлаа.

10 дугаар зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2023 оны төсвийн жилд 132,718.6 сая төгрөгийн хэмжээтэй хөрөнгө хуримтлуулна.

Санал хураалт явуулъя.

50 гишүүн дэмжиж, 10 дугаар зүйл батлагдлаа.

11 дүгээр зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд 2023 оны төсвийн жилд 540,000.0 сая төгрөгийн хэмжээтэй хөрөнгө хуримтлуулна.

Санал хураалт явуулъя.

48 гишүүн дэмжиж, 11 дүгээр зүйл батлагдлаа.

12 дугаар зүйл. 2023 оны төсвийн жилд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг доор дурдсанаар баталсугай:

12.1.Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.1, 12.1.3 болон 12.1.6-д заасан зориулалтаар Засгийн газрын хийх гадаад, дотоод зээллэгийн дээд хэмжээг 2,828,685.6 сая төгрөг хүртэл;

12.2.Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 1,224,500.0 сая төгрөг хүртэл.

Санал хураалт явуулъя.

50 гишүүн дэмжиж, 12 дугаар зүйл батлагдлаа.

13 дугаар зүйл. Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2023 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 2,760,217.3 сая төгрөг байна.

Санал хураалт явуулъя.

47 гишүүн дэмжиж, 13 дугаар зүйл батлагдлаа.

14 дүгээр зүйл. Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ 2023 оны төсвийн жилд 3,730,335.0 сая төгрөг байна.

Санал хураалт явуулъя.

51 гишүүн дэмжиж, 14 дүгээр зүйл батлагдлаа.

15 дугаар зүйл. Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2 болон 12.1.4-т заасан зориулалтаар Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

Санал хураалт явуулъя.

50 гишүүн дэмжиж, 15 дугаар зүйл батлагдлаа.

Гуравдугаар бүлэг

Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг

16 дугаар зүйл. 2023 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэг олгоно:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	17,505.9
2	Баян-Өлгий	10,252.4
3	Баянхонгор	19,843.9
4	Булган	8,373.5
5	Говь-Алтай	15,649.3
6	Дундговь	14,132.3
7	Завхан	17,716.3
8	Өвөрхангай	19,278.1
9	Сүхбаатар	8,293.2
10	Төв	8,339.8
11	Увс	17,414.5
12	Ховд	11,792.6
13	Хөвсгөл	21,972.4
14	Хэнтий	21,272.6
15	Говьсүмбэр	2,112.2
Нийт дүн		213,949.0

Санал хураалт явуулъя.

47 гишүүн дэмжиж, 16 дугаар зүйл батлагдлаа.

17 дугаар зүйл. 2023 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Аймаг, хот	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
-----	------------	---

1	Дорноговь	8,783.7
2	Дорнод	3,623.9
3	Өмнөговь	273,591.2
4	Сэлэнгэ	4,318.4
5	Дархан-Уул	1,856.1
6	Улаанбаатар	593,446.3
7	Орхон	142,966.5
Нийт дүн		1,028,586.1

Санал хураалт явуулья.

49 гишүүн дэмжиж, 17 дугаар зүйл батлагдлаа.

18 дугаар зүйл. 2023 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна.

Д/д	Аймаг, хот	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	8,580.8
2	Баян-Өлгий	8,028.7
3	Баянхонгор	12,601.5
4	Булган	7,525.9
5	Говь-Алтай	12,193.8
6	Дорноговь	22,531.6
7	Дорнод	17,943.1
8	Дундговь	9,816.0
9	Завхан	11,932.6
10	Өвөрхангай	9,808.2
11	Өмнөговь	23,276.2
12	Сүхбаатар	13,702.0
13	Сэлэнгэ	16,630.7
14	Төв	16,368.6
15	Увс	9,096.3
16	Ховд	15,287.6
17	Хөвсгөл	11,546.8
18	Хэнтий	10,112.4
19	Дархан-Уул	10,811.6
20	Улаанбаатар	32,499.7
21	Орхон	13,552.1
22	Говьсүмбэр	4,632.4
Нийт дүн		298,478.5

Санал хураалт явуулья.

49 гишүүн дэмжиж, 18 дугаар зүйл батлагдлаа.

Дөрөвдүгээр бүлэг **Бусад зүйл**

19 дүгээр зүйл. “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Санал хураалт явуулъя.

48 гишүүн дэмжиж, 19 дүгээр зүйл батлагдлаа.

20 дугаар зүйл. “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Санал хураалт явуулъя.

47 гишүүн дэмжиж, 20 дугаар зүйл батлагдлаа.

21 дүгээр зүйл. “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд эргэн төлөлт хийх концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

Санал хураалт явуулъя.

49 гишүүн дэмжиж, 79 хувийн саналаар 21 дүгээр зүйл батлагдлаа.батлагдлаа.

22 дугаар зүйл. “Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2023 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал”-ыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

Санал хураалт явуулъя.

48 гишүүн дэмжиж, 22 дугаар зүйл батлагдлаа.батлагдлаа.

23 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт явуулъя.

47 гишүүн дэмжиж, 79 хувийн саналаар 23 дугаар зүйл батлагдлаа.батлагдлаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг зүйл бүрээр санал хураалт явуулж, баталж дууслаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

49-өөс дээш буюу нийт гишүүдийн олонхоор хууль эцэслэн батлагдана гэдгийг тодруулж хэлье. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.1-д заасны дагуу хууль эцэслэн батлах санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

50 гишүүн дэмжиж, төсөв батлагдлаа.

Одоо Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн зүйл заалт бүрийг уншиж сонсгон зүйл, заалт тус бүрээр нь санал хураалт явуулна.

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай

Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2023 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Санал хураалт явуулъя.

44 гишүүн дэмжиж, 1 дүгээр зүйл батлагдлаа.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Санал хураалт явуулъя.

44 гишүүн дэмжиж, 2 дугаар зүйл батлагдлаа.

Хоёрдугаар бүлэг Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн орлого, зарлага

3 дугаар зүйл.*Нийгмийн даатгалын санд 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:*

<i>Д/д</i>	<i>Орлогын төрөл</i>	<i>Дүн /сая төгрөгөөр/</i>
<i>1</i>	<i>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</i>	<i>3,739,338.0</i>
	<i>1.1 Ажил олгогчийн төлөх шимтгэл</i>	<i>1,705,275.6</i>
	<i>1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл</i>	<i>1,297,191.7</i>
	<i>1.3 Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл</i>	<i>15,143.9</i>
	<i>1.4 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл</i>	<i>172.1</i>
	<i>1.5 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл</i>	<i>161,725.3</i>
	<i>1.6 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл</i>	<i>3,302.6</i>
	<i>1.7 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл</i>	<i>2,341.0</i>
	<i>1.8 Бусад орлого</i>	<i>8,973.1</i>
	<i>1.9 Төр хариуцах иргэдийн тэтгэвэр, шимтгэл</i>	<i>545,212.7</i>
<i>Нийт орлого</i>		<i>3,739,338.0</i>

Санал хураалт явуулъя.

45 гишүүн дэмжиж, 3 дугаар зүйл батлагдлаа.

4 дүгээр зүйл.*Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө:*

<i>Д/д</i>	<i>Төсвийн ерөнхийлөн захирагч</i>	<i>Дүн /сая төгрөгөөр/</i>
<i>1</i>	<i>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</i>	<i>68,363.4</i>

Санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, 4 дүгээр зүйл батлагдлаа.

5 дугаар зүйл.*2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсөв зарцуулна:*

<i>Д/д</i>	<i>Зарлагын төрөл</i>	<i>Дүн /сая төгрөгөөр/</i>
<i>1</i>	<i>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</i>	<i>3,748,030.1</i>
	<i>1.1 Тэтгэврийн даатгалын сан</i>	<i>3,338,768.4</i>
	<i>1.2 Тэтгэмжийн даатгалын сан</i>	<i>229,981.2</i>
	<i>1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан</i>	<i>40,425.7</i>
	<i>1.4 Ажилгүйдлийн даатгалын сан</i>	<i>80,295.3</i>
	<i>1.5 Үйл ажиллагааны урсгал зардал</i>	<i>37,010.1</i>
	<i>1.6 Даатгуулагчид буцаан олгох нийгмийн даатгалын шимтгэлийн зардал</i>	<i>21,549.4</i>
<i>Нийт зарлага</i>		<i>3,748,030.1</i>

Санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, 5 дугаар зүйл батлагдлаа.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, 6 дугаар батлагдлаа.

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийг зүйл бүрээр баталлаа.

Одоо Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

45 гишүүн дэмжиж, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай батлагдлаа.

Одоо Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг зүйл, заалт тус бүрээр нь уншиж сонсгон санал хураалт явуулна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай

Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Эрүүл мэндийн даатгалын санд 2023 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Санал хураалт явуулъя.

44 гишүүн дэмжиж, 1 дүгээр зүйл батлагдлаа.

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн хууль тогтоомж

2.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Санал хураалт явуулъя.

48 гишүүн дэмжиж, 2 дугаар зүйл батлагдлаа.

Хоёрдугаар бүлэг
Эрүүл мэндийн даатгалын сангийн
2023 оны төсвийн орлого, зарлага

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын санд 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ.

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	1,481,369.2
	1.1 Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	539,439.3
	1.2 Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	226,922.5
	1.3 Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	687,445.3
	1.4 Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	27,562.1
Нийт орлого		1,481,369.2

Санал хураалт явуулъя.

45 гишүүн дэмжиж, 3 дугаар зүйл батлагдлаа.

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө.

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	85,000.0

Санал хураалт явуулъя.

47 гишүүн дэмжиж, 4 дүгээр зүйл батлагдлаа.

5 дугаар зүйл. 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулна.

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	1,481,369.2
	1.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт	628,223.7
	1.2 Төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	713,611.9
	1.3 Эмийн санд олгох	89,982.5

1.4 Үйл ажиллагааны урсгал зардал	9,551.1
1.5 Эрсдэлийн сан	40,000.0
Нийт зарлага	1,481,369.2

Санал хураалт явуулъя.

46 гишүүн дэмжиж, 75.4 хувийн саналаар батлагдлаа.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт явуулъя.

45 гишүүн дэмжиж, 6 дугаар зүйл батлагдлаа.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийг зүйл бүрээр санал хураалт явуулж, баталж дууслаа.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа. Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр өргөн барьсан 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурал эцэслэн баталлаа.

Ажлын хэсгийг ахалж ажилласан Улсын Их Хурлын гишүүн Төсвийн байнгын хорооны дарга Тэмүүлэн болон асуудалд шуурхай ажил хэрэгч хандаж төсвийн шинэчлэл хийх томоохон зорилтыг дэвшүүлье. Идэвх санаачилгатай ажилласан нийт гишүүддээ Улсын Их Хурлын Тамгын газрын ажлын дэд хэсгийн хамт олонд талархал илэрхийлье. Дөнгөж сая батлагдсан Монгол Улсын 2023 оны

төсөв дараах онцлогуудтай боллоо. Тодорхой өөрчлөлтүүдэд төсвийн шинэчлэлийг эхлүүлээ.

1 дүгээрт төсвийн алдагдлыг өргөн барьсан төслөөс 127.6 тэрбум төгрөгөөр багасгалаа төсвийн алдагдлыг.

ДНБ-д эзлэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг тодорхой хувиар сайжрууллаа.

2 дугаарт зардлыг бууруулах тэвчиж болох зардлыг танах замаар төсвийн зардлыг 176.9 тэрбум төгрөгөөр буурууллаа. Энэ эх үүсвэрээр улсын хэмжээнд 10 мянгаас дээш хүн амтай хот суурины гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийг эдлүүлнэ. Энэ арга хэмжээнд нийтдээ 173600 өрх хамрагдана. Тарифын хөнгөлөлтийг эдлүүлж байна. Эрчим хүчний.

Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ард иргэддээ элэгний өвчлөл хорт хавдраас урьдчилан сэргийлэх эмчлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Энэ бол ард иргэдийнхээ эрүүл мэндэд анхаарч байгаа онцгой төсөв

гэж хэлж болно. Хүүхэд хамгаалах арга хэмжээний зардлыг нэмэгдүүллээ. Өнөр бүлээс авхуулаад хүүхэд хамгаалал, хүүхэд дээ анхаарлаа хандуулж төсөв нэмэгдүүллээ. Шинэ сэргэлтийн бодлого, боомтын сэргэлтийг дэмжих, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний зорилтуудыг бодитой ажил хэрэг болгоход зориулан тодорхой санхүүжилтийг шийдвэрлэлээ. Энэ хэмнэсэн 176.9 тэрбум төгрөгөөр.

3 дугаарт шинэ хөрөнгө оруулалт хийхгүй байх. Өмнө нь нэгэнт эхэлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээг 2023 онд багтаан дуусгах бодлогыг хуульчиллаа.

Ингэхдээ боловсрол, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг тэргүүн ээлжид шийдвэрлэх төсөв 2023 олон нийтийн хэлэлцүүлгээр ард иргэдийн хөндсөн зарим асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг хийлээ.

Ер нь түүхэндээ анх удаа улсын төсвийг олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Анх удаа шинэ хэлэлцүүлгийг манай Төсвийн байнгын хороо зохион байгууллаа. Төсөв 2023 хэлэлцүүлэг.

Тэгээд иргэдээс хөндсөн асуудлуудыг шийдвэрлэлээ. Тухайлбал нийт 65 сургууль цэцэрлэг, эрүүл мэндийн 19 төвийн санхүүжилт зохицуулагдаж байна. Эдгээр дотоод Сонгинохайрхан дүүргийн 300 иргэдийн саналаар тус дүүргийн 12 дугаар сургуулийг барьж дуусгахаар тусгалаа. Мөн Хан-Уул дүүргийн 80 иргэний саналаар тус дүүргийн 115 дугаар сургуулийн барилгын сургуулийг ашиглалтад оруулахаар боллоо. Эдгээр сургуулиуд зориулалтын бус байранд 3

ээлжээр сургалтын үйл ажиллагаа явуулж байсан юм.

Төсвийн шинэчлэлийн хүрээнд Улсын Их Хурлын тогтоолыг баталж тодорхой шинэчлэлүүдийг эхлүүлж хэрэгжүүлж чадлаа. Төрийн өмчит компаниудын санхүүгийн сахилга бат, хяналт хариуцлагыг сайжруулах ил тод нээлттэй байдлыг дээшлүүлэх зорилгоор төрийн өмчийн компаниудын нэгдсэн цахим бүртгэл мэдээллийн системийг бий болгох ашигт малтмал олборлох боловсруулах тээвэрлэх бүх үе шатанд хамаарах гэрээг татварын нэгдсэн системд бүртгүүлж экспортод гаргах нууцын зэрэглэлд хамаарах, худалдах худалдан авах бүхий л гэрээг улирал бүр Улсын Их Хуралд танилцуулж байхаар тусгалаа. Ингэхээр одоо тэр нүүрсний хулгайтай Улсын Их Хурал тууштай тэмцэх зорилгоор байгуулсан тэр боомтын ажлын хэсэг, хяналт шалгалтын ажлын хэсгүүд, хөгжлийн банкттай холбоотой асуудлуудыг ил тод болгож ард түмэнд мэдээлэх, ард түмний мэдэх эрхийг хангах үүргээ Улсын Их Хурал бас тууштай хэрэгжүүлж чадаж байна гэж үзэж байна. Цаашидаа энэ хяналтыг улам чангатгах ийм зорилтыг шаардлагыг дэмжлээ.

Хувьцаат компани, төрийн өмчит компаниудын засаглал ил тод байдлыг хангахаар олон нийтийн хяналтыг сайжруулах зорилтыг дэвшүүлнэ. Тэр худалдан авалт хөрөнгө оруулалт, татвар, өр төлбөр, хүний нөөцийн мэдээлэл, сонирхлын зөрчил болон харилцан хамаарал бүхий этгээдийн хийж буй хэлэлцээрийн их хэмжээний хэлцэл, өр авлага, захиран зарцуулалт ард түмэнд ил тод нээлттэй байлгах зарчмыг баримтлахыг чиглэл болгож орууллаа.

Төрийн өмчийн компаниудыг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх, Хувийн хэвшилийн оролцоог нэмэгдүүлэх, Компанийн засаглалыг сайжруулах цогц бодлого боловсруулах даалгаврыг өглөө. Төрийн үйлчилгээний байгууллагуудад нэмэлт орлого олох, зарцуулах эрхийг нээж өглөө. Шинэ хөрөнгө оруулалтыг тухайн жилд санхүүжих дүнг 3 жилийн дотор бүрэн санхүүждэг байх зарчмыг бий болголоо. Төсвийг олон хуваахыг хориглолоо. Төрийн үүргийг хариуцлагажуулах зэрэг шинэчлэлийн зорилтуудыг энэ удаагийн төсвөөс эхлэн дэвшүүлж байна. Улсын Их Хурлаас баталсан энэ өөрчлөлт шинэчлэлтийг тууштай хэрэгжүүлэхэд Засгийн газар онцгой анхаарч ажиллахыг чиглэл болгож байна.

Төсвийн болон хөрөнгө оруулалтын шинэчлэлийн бодлого маань үр дүнд хүрч төсвийн бодлого, төсвийн хэмнэлтийн бодлогоор дамжин улс орны эдийн засаг богино хугацаанд сэргэнэ гэдэгт итгэлтэй байна. Тэгээд одоо төсвийн хуулиа батлаад байх биш хэрэгжилтийг нь хангах талаар үр ашигтай байлгах талаар Төсвийн байнгын хороо тасралтгүй хяналт тавьж ажиллахаар хуульчлагдсан сая. Үүнийхээ араас одоо Төсвийн байнгын хороо сар, улирал болгон хяналт тавьж Төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулахаар чиглэл болгож байна.

Ингээд төсөв батлагдлаа баяр хүргэе. Төсвийн байнгын хороо, Төсвийн ажлын хэсэг, идэвхтэй ажилласан бүх гишүүддээ баярлалаа.

Одоо дараагийн асуудалдаа орно. Дагасан тогтоолоо батална.

Гишүүд байж байгаарай. Саяын зорилтуудыг тусгасан тогтоолыг баталж байгаа. Үүрэг чиглэл болгож байгаа.

Төсвийн хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батална.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо санаачлан боловсруулж тодорхой заалтуудыг оруулсан.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл батална. Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна.

Санал хураалт явуулна гишүүд байж байгаарай. Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

52.4 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа. Саяын хэлсэн саналуудыг тогтоолд тусгасан байгаа. Зарчмууд, үүрэг даалгавар болгож байгаа.

Дараагийн асуудалд орно.

Дэгийн тухай хуульд заасны дагуу үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцдэг санал, асуулгын хариуг хэрвээ боломжтой бол үдээс өмнөх чуулганы нэгдсэн

хуралдаанаар хэлэлцэж болно гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханаас Эрүүл мэндийн сайдад хандаж хүн амын нийтийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар тавьсан асуулгын хариуг сонсоно.

Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханаас Эрүүл мэндийн сайд хандаж Хүн амын эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаас тавьсан асуулгын хариуг сонсоно.

Асуулгад Эрүүл мэндийн сайд Сэрээжавын Энхболд хариулна.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя. Ажлын хэсгийн гишүүд танилцуулна.

Асуулгад Эрүүл мэндийн сайд Сэрээжавын Энхболд хариулна. Индэрт урьж байна Энхболд сайдыг.

С.Энхболд: Эрхэм хүндэтгэх Их хурлын дарга, эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Улсын Их Хурлын гишүүн Баярсайханаас Хүн амын нийтийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай асуулгын хүрээнд Эрүүл мэндийн яамны зүгээс хийж хэрэгжүүлсэн ажлыг товч танилцуулж байна.

Асуулт нэг. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоонд хамрагдах, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх:

Энэ асуулгын хүрээнд

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, алсын хараа 2050 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Монгол Улсын нийт иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ ажиллагаанд хамруулж эхэлсэн. 2022 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн байдлаар эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд улсын хэмжээнд 501739 хүн хамрагдсан байна.

Үзлэгийн дүгнэлт гарч дууссан, хүн амаас өвчлөлийн 269143 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн байна.

Тухайлбал, хорттой болон хоргүй хавдрын 1965 тохиолдлыг илрүүлж, онош тодруулах, баталгаажуулахаар дараагийн шатны эмнэлэгт илгээж, хорт хавдрын 135 шинэ тохиолдлыг одоогоор баталгаажуулсан байна. Өвчнийг эрт илрүүлэх дэд бүтцийг бий болгох зорилгоор 2020-2022 онд нийт 38.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 20 аймаг, 5 дүүрэг, 2 хөдөөгийн нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийн төвд 20 гаруй конниттой уян дуран, тархины цахилгаан бичлэгийн аппарат, чих хамар хоолой, оношилгоо, тоног төхөөрөмж суурь, дижитал суурин дижитал рентген аппарат, суурин эхо зэрэг тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан иж бүрэн эрүүл мэндийн дэмжих төвийг байгуулж, иргэдэд урьдчилан сэргийлэх, эрт хэтрүүлэх тусламж үйлчилгээг үзүүлж байна аа.

Мөн 18-аас 30 насны иргэдийн хамрагдалт сул байгаа учраас бид нар Эрүүл мэндийн яамны зүгээс Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран Оюутны эрүүл мэндийг

дэмжих эрт илрүүлэгт хамрагдах эерэг хандлага, эрүүл оюутан аянг 10 дугаар сараас эхлүүлэн үзлэг оношилгоо, шинжилгээнд хамруулж байна. Хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох бага наснаас нь эрүүл мэнддээ анхаарал хандуулдаг дадалтай болгоход эрүүл мэндийн боловсрол, хичээл гол үүрэг гүйцэтгэгч гэж үзэж байна. Эрүүл мэнд хичээлийн сургалтын хөтөлбөрт хооллолт, хоол тэжээл, хувийн болон орчны эрүүл мэнд, хооллолт, хөдөлгөөн, сэтгэцийн эрүүл мэнд, хорт зуршил, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендерт суурилсан хүчирхийлэл зэрэг бүлгийг бол энэ хичээлийн сэдэвт багтаасан болно оо.

Мөн БШУЯ болон НҮБ-ын Хүүхдийн сан, СЭМҮТ-тэй хамтран анги удирдсан багшаар дамжуулан эцэг эхийн боловсролыг дэмжих арга зүйн зөвлөмжийг бол боловсруулан ажиллаж байна аа.

Асуулт 2-4-т агуулга нэг байгаа учраас нэгтгэн хариултыг хэлье ээ.

Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай үзэл, хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 8 дугаар захирамжийн дагуу байгуулагдсан эрүүл мэндийн салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд холбогдох хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэнгийн 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн Ажлын

дэд хэсгийг байгуулах тухай Нэгдүгээр шийдвэрийн дагуу Ажлын дэд хэсгийн ахлагч, Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн Ажлын албанд 2022 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн А/3191 тоот албан бичгээр Нийтийн эрүүл мэндийн тухай хуулийг өргөн барьсан болно оо.

Эрүүл дадалтай, хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд 2021-2022 онд Эрүүл чийрэг эр хүн, Эрүүл идэвхтэй амьдрал, Хавдрын эсрэг, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд, харшлаас сэргийлэх, орчны эрүүл мэнд, халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаант эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшний үндэсний судалгаа, хүн амын хоол тэжээлийн байдалд үнэлгээ хийх, үндэсний 1, 2, 3, 4, 5 дугаар судалгаа зэрэг судалгаа шинжилгээний үр дүн, нотолгоонд үндэслэн өвчлөлд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах, устгах арга хэмжээг төлөвлөлтөд тусгасан. 2019 онд хийгдсэн халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх үндэсний судалгааны халдварын бус өвчний 2 дахь эрсдэлт хүчин зүйл нь илүүдэл жин болон таргалалт байсан.

5 хүртэлх насны хүүхдийн 11.7 хувьд нь 6-11 настай хүүхдийн, 28.6 хувь нь таргалалттай байгаад хүн амын хоол тэжээлийн үндэсний 5 дугаар судалгаагаар тогтоосон байдаг аа. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон зүрх судасны өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж,

бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор ДЭМБ-аас Пэн хайртс загвар төслийг санаачлан б санаачилсан бөгөөд Манай улсын 2019 оноос эхлэн Сонгинохайрхан дүүрэг, Дархан Уул аймаг, Говьсүмбэр, Дундговь, Дорнод, Завхан, Хөвсгөл аймгийн 132 ЭМТ-д хэрэгжүүлж байна.

Төсөл хэрэгжсэн аймаг орон нутгийн тархины цус харвалтаас шалтгаалсан нас баралтын тоо 1.4-2.5 болтол буурсан. Зүрхний шигдээсийн шинэ тохиолдлын тоо 2022 оны 2 дугаар улиралд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.9 дахин, нас баралтын тоо 1.5 дахин тус тус буурсан үр дүн гарсан тул энэхүү төслийг 2024 он гэхэд уг төсөлд хамрагдаагүй бүх аймгуудыг хамруулахаар ажиллаж байна. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх зорилгоор илүүдэл жингүй, эртэч Монгол эрүүл мэндийнхээ төлөө алхмаа ярилицья, хариад амарья, хамтраад шийдье, цэх бай, цэгцтэй хоолны зэрэг компани т арга хэмжээг зохион байгуулж, иргэд нийгмийн бусад салбарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, нөлөөлөх ажлыг зохион байгуулж байна.

Асуулт тав. Нярай болон бага насны хүүхдийг халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ, цаашид баримтлах бодлогын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж гэдэг нь хүүхдийг төрөнгүүт үзүүлэх тусламж бөгөөд энэ тусламжийг зөв, шуурхай үзүүлснээр нялхсын эндэгдлийн зонхилох хувийг эзэлдэг нярайн эндэгдлийг бууруулахад чухал нөлөө үзүүлдэг ээ.

Эрүүл мэндийн яам нярайн нэн шаардлагатай тусламжийг сайжруулах асуудлаар 21 аймаг болон нийслэлийн амаржих газруудын дарга болон эх барихын эмч нарыг оролцуулсан үндэсний зөвлөгөөн зохион байгуулж, зөвлөмж гаргасан. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн үндэсний сургагч багш нарыг бэлтгэн, тэднийг орон нутагт илгээн бүсчилсэн сургалтууд зохион байгуулж, нярайд үзүүлэх ур чадварыг сайжруулж байна. Үүний үр дүнд энэ оны эхний 10 сарын байдлаар нярайн эндэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мянган амьд төрөлтөд 8.5-7.6 болж буурсан. Нярайн эрт илрүүлэг үзлэг шинжилгээ, оношилгооны эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр цусны хатаасан толбонд нярайн скрининг шинжилгээ хийх заавар нярайн скрининг шинжилгээг төрөлхийн, гипотероз өвчнийг илрүүлэх, нярайн скрининг шинжилгээгээр адернальгенитол хам шинжийг илрүүлэх зааврыг тус тус батлан хэрэгжүүлж ажиллаж байна аа.

Төрөлхийн хөгжлийн гажгийг эрт илрүүлэх зорилгоор шинээр төрсний дараа түүх сонсгол, Вертина Патын скрининг шинжилгээ хийж эмгэг илэрсэн тохиолдолд батлагдсан эмнэл зүйн зааврын дагуу оношилгоо, эмчилгээ хийж байна. Удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чиглэлээр нярайн скрининг шинжилгээг Анагаах ухааны удам зүйн лабораторид хийж байна. Уг лабораторийн үйл ажиллагаа эхэлснээс хойш төрөхийн болон төрөхийн өмнөх илрүүлэх шинжилгээ нийт 25216 үйлчлүүлэгчид төрөхийн өмнөх онош батлах Зита генетик шинжилгээг 8 жилийн хугацаанд 1346 үйлчлүүлэгчид хийснээс 216 хромсомын

тооны болон бүтцийн өвчнүүд оношлогдсон.

Дутуу нярайд амьсгалын дистресс, уушгины дутуу хөгжил, түүнээс үүдсэн хүнд эмгэгийг сэргийлэх зорилгоор нярайн практикт блендерийн системийг ашиглан өндөр урсгалаар хүчилтөрөгчийн урсгал бүлээсгээж чийгшүүлж өгөх аргыг мөн хэрэгжүүлж ажиллаж байна аа.

Дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 185 дугаар тогтоолыг улсын хэмжээнд мөрдөн ажиллаж байна. Уг тогтоолд зааснаар заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу 10 халдварт өвчний эсрэг 6 төрлийн вакцинаар 0-15 насны хүүхдийг дархлаажуулалтын хамралт 95 хувиас дээш хамааралтай байна аа.

Асуулт 6.

Хавдрын эсрэг тэр дундаа хүүхдийн хорт хавдартай тэмцэх хүрээнд хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон өнөөдрийг хүртэлх хугацаанд хорт хавдар, өвчтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг цаашид баримталж буй бодлогын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

Монгол Улс хүүхдийн хорт хавдрын эсрэг ДЭМБ-ын глобал санаачилгыг дэмжин Эрүүл мэндийн сайдын ивээл дор 2020 онд зохиогдсон Хавдаргүй үрс үндэсний анхдугаар зөвлөгөөний зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор хүүхдийн хорт хавдрын тусламж, үйлчилгээг эрчимжүүлэх 2021-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Эрүүл мэндийн сайдын

2021 оны 201 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна аа.

Хүүхдийн хорт хавдрын тусламж үйлчилгээнд оролцогч бүх шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа болон анхан лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний уялдаа холбоог хангах чиглэл, хүүхдийн хорт хавдрын бүртгэл, хяналтын тогтолцооны ерөнхий бүдүүвч, хүүхдийн хорт хавдрын үед үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөл ба оролцогч байгууллагуудын үйлчилгээний зохион байгуулалтын нэгдсэн зураглал, хүүхдийн хорт хавдрын тусламж, үйлчилгээг эрчимжүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын болон үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, шалгуур үзүүлэлт, хүрэх зорилтот түвшинд тодорхойлох шалгуур үзүүлэлтийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 501 дүгээр тушаалаар баталсан. Хүүхдийн хорт хавдрын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар өвчлөл, нас баралтыг бууруулахад хамааралтай бүх талуудын оролцоог чиглүүлэн нэмэгдүүлэх, тэдгээрийн хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах механизм бүрдүүлэх зорилгоор хүүхдийн хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлэгч талуудыг оролцуулсан Хүүхдийн хавдрын зөвлөл байгуулан ажиллаж байна.

2022 онд хэрэгжүүлж буй эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ оношилгооны 1 онцлог нь 0-17 насны хүүхдийн 2 багцыг нэмж оруулж ирсэн онцлогтой бөгөөд одоогоор 300 гаруй мянган хүүхэд хамрагдсанаас 129363 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн. Энэ бүртгэгдсэн тохиолдлоос шүд цоорох өвчлөл 74.7 хувь, шүдний гажиг 2.9, хараа муудах

1.7 хувийг эзэлж тэргүүлэх өвчлөл зонхилж байна. Хүүхдийн өвчлөлийн дунд хавдрын 68 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 0-5 настай хүүхдийн дунд 20 тохиолдол, 6-17 насны хүүхдийн дунд 48 тохиолдол бүртгэгдэж, онош баталгаажсан 4 тохиолдлыг эмчилгээний асуудлыг үргэлжлүүлэн хийгдэж байна.

Асуулт 7.

Дээрх асуултуудад дурдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр зорилтот үр дүнд гарч буй эсэх, хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга замын талаар Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа, хөгжлийн цогц бодлого, алсын хараа 2050-д тусгагдсан бодлогыг хэрэгжүүлснээр Монгол хүний дундаж наслалтыг нэмэгдүүлж, эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг бууруулж, дэлхийн жишигт хүргэх, эрүүл, чанартай амьдрах нөхцөлийг бий болгох бүрэн боломж байна аа.

Гагцхүү энэ зорилтод хүрэхэд агаар, орчны бохирдол, хүнсний аюулгүй байдал, амьдрах орчны нөхцөл, осол гэмтэл, ядуурал зэрэг хүний эрүүл мэндэд нөлөөлж буй хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн сөрөг хүчин зүйлсийг нөлөөллийг бууруулах, олон салбарын оролцоог хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна аа.

Цаашид нийгмийн эрүүл мэндийн хууль эрх зүйн орчныг сайжруулах тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн хүний нөөцийг бэлтгэх стандартад заасан орон тоогоор тогтвор суурьшилтай ажиллуулах. Нийгмийн

эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог шинэчлэн, тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай хөрөнгийг нь нэмэгдүүлэх, улсын хэмжээнд өвчний хяналт сэргээлтийн төв, орон нутагт Нийгмийн эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн дэмжих төвийг түшиглэн хүн амд чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх. Эрүүл мэндийг нь дэмжих, хүн амын эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг хүн амын өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах. Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл амьдрах зан үйл хэвшүүлэх, иргэдэд ээлтэй, эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд эрүүл мэндийн бус салбар, орон нутгийн өөрөө удирдах болон засаг захиргааны байгууллагуудын оролцоо, санхүүжилтийг нэмэгдүүлэх.

Монгол Улсын хүн амд зохистой хооллолтыг төлөвшүүлэх. Шим тэжээлийн боловсрол асуудлыг сургуулийн үдийн хоолоор дамжуулан хэрэгжүүлэх. Бүх төрлийн согтууруулах ундаа, тамхи сахрын агууламж өндөртэй бүтээгдэхүүнд ногдуулах татварыг үе шаттай нэмэгдүүлэх замаар хорттой хэрэглээг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Товч танилцуулж дууслаа.

Г.Занданшатар: Эрүүл мэндийн сайд Сэрээжавын Энхболдод баярлалаа, мэдээлэл хийлээ.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Батсүхийн Буянтогтох, тус яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга Жигжидхорлоогийн Нарангэрэл, тус яамны Нийтийн эрүүл мэндийн газрын

дарга Бүдрагчаагийн Баярболд, тус яамны Санхүү эдийн Засгийн газрын дарга Тогтохын Мөнхзул, ХӨСҮТ-ийн ерөнхий захирал Цолмонгийн Билэгтсайхан, НЭМҮТ-ийн ерөнхий захирал Сүрэнжавын Өнөрсайхан, СЭМҮТ-ийн ерөнхий захирал Ванчиндоржийн Баярмаа нар байна. Ажлын хэсэг танилцууллаа.

Асуулгын хариулттай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд. Гонгорын Дамдинням, Баагаагийн Баттөмөр гишүүнээ тасаллаа. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа.

Гишүүн их чухал сэдвээр асуудал асууж байна. Ер нь бол Эрүүл мэндийн яамны 2 чиг үүрэг байгаа. Нэг нь өвчтэй хүмүүс эмчилдэг, нөгөөдөх нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн. Энэ чиглэлийн нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн буюу өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцинжуулах. Мөн одоо иргэдээ эрүүл мэндийн боловсролтой болгох. Нийгмийг хамарсан өвчнүүдийг устгах чиглэлд тодорхой хөтөлбөрүүд хэрэгжүүлэх гээд энэ чухал ажлууд байгаа. Тэгэхлээр энэ ажлууд дотор бол ер нь Монгол хүн эрүүл байх 2020 оны одоо Их Хурлын сонгуулиар ялсан, энэ байгуулагдсан Их Хурал, Засгийн газарт бол өгсөн гол чиг үүрэг бол Монгол хүний дундаж насыг 4 насаар нэмэх том зорилго тавьчихсан байгаа. Яах вэ, цар тахалтай хэцүү 2 жил өнгөрлөө. Энийг бол бүгд ойлгож байгаа. Харин азаар Монгол Улс, Засгийн газар сайн ажилласны хүрээнд бид нар хохирол багатай давж чадсан ийм чухал үеийг өнгөрөөгөөд явж байна. Тэгсэн хэдий ч гэсэн дараагийн бас корона вирусийн хувилбарууд гаргах, энэ бол одоохондоо бүр

дуусчихсан гэж хэлэх ямар ч одоо боломж байхгүй.

Гэхдээ нэг сайн тал бол бид вакцинжуулалтаа сайн хийж чадсантай холбоотой хүндрэл, эрсдэл харьцангуй гайгүй байна. Тэгэхээр бид эрүүл хүн гэдэг яаж хүмүүсээ эрүүл байлгах вэ гэдэг дээр ерөөсөө чухал асуудал бол хүний эрүүл мэндийн боловсролын асуудал. Тэр дотроо бага наснаас нь авхуулаад л бид эрүүл мэндийн боловсролыг, эрүүл амьдрах ухааныг дадлагажуулах гэдэг бол шал өөр зүйл, тийм ээ. Тэгэхээр бид дадлагажуулахын төлөө юу хийж байна вэ гэдэг дээрээ өөрсдөдөө байнга асуулт тавьж байх ёстой. Тухайлах юм бол бид одоо тарган байх, тамхи татах, архи уух гэдэг бол өөрөө хорт хавдар үүсгэх гурван шалтгааны 30 хувийг эзэлдэг гэдгийг бүгдээрээ мэднэ. Энийг ярьсан. Одоо гагцхүү амьдралдаа яаж хэрэгжүүлэх юм. Яаж тамхи татахгүй байх юм, яаж архи уухгүй байх юм. Яаж одоо илүүдэл жингүй байх юм бэ гэдэгт. Тэгэхээр энэ чиглэлд Эрүүл мэндийн яамны одоо яг боловсруулж хийж байгаа, манлайлж байгаа ажлууд чухал байна. Энэ талаар одоо бүр тодорхой зүйлүүдийг яриач ээ.

Ялангуяа одоо Тамхины хуулийн нэмэлт, өөрчлөлт байна. Энэ электрон тамхины хэрэглээ хязгаар юу хяналтгүй байна? Татваргүй байна? Архи тамхины хэрэглээнээс орж ирж байгаа татвараа бид эрүүл мэндийн боловсрол, эрүүл амьдрах ухаанд хэр их хүчтэй эм оруулж ирж чадаж байна? Энэ дээр одоо яаж Их Хурлаар дэмжих вэ? Туслах вэ? Их хурлын даргын захирамжаар байгуулагдсан энэ ажлын хэсэг бол тэр чигтээ эрүүл мэндийн эрх зүйн шинэчлэл хийхэд Эрүүл мэндийн яам дэмжлэг үзүүлэх зорилготой ийм ажлын хэсэг байгаа

шүү дээ. Тэгэхээр энэ чиглэл дээр бүгдээрээ одоо энэ илүү түлхүү яаж ажиллах вэ гэдэг дээр чухал ажиллах хэрэгтэй. Ди парламент дээр бол нийгмийн эрүүл мэндийн асуудал орсон байгаа хэдий ч бас яг одоо тийм бодитой сайн болж байгаа гэдэг зүйл бол харагдахгүй байгаа. Ялангуяа анхан шатны тусламж үйлчилгээн дээр нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн тусламж үйлчилгээг яаж бодитой хүрэх вэ гэдэг дээр сайд нэг хариулт өгөөч.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? 87.

Б.Буянтогтох: Эрхэм гишүүн Чинбүрэн гишүүний асуултад Тамхины хяналтын тухай хуулийн асуудлаар ямар явцтай явж байгаа талаар асуултад хариулъя. Тамхины хяналтын тухай хууль маань яамдуудаасаа саналаа авчихсан. Хууль зүйн яамнаас саналаа авсан. Сангийн яам дээрээ одоо саналаа харахаар явж байна. Холбогдох газрын дарга нар удирдлагуудтай бид нар бас яамтайгаа хамтраад уулзалтуудаа хийгээд зөвшилцсөн шатандаа явж байна.

Одоо Сангийн яамнаас бол Засгийн газраар орох зөвшөөрөл ирчихвэл бид нар Засаг руугаа оруулаад, тэгээд Их Хуралдаа өргөн барина. Тамхины хяналтын тухай хууль дээр энэ удаа орж байгаа өөрчлөлт бол электрон тамхийг бол зохицуулахаар оруулж ирж байгаа. Мөн дагалдаад Онцгой албан татварын тухай хуулиуд дээр тамхитай холбоотой татваруудын асуудлуудыг би бас оруулж ирж байна. Ер нь бол ДЭМБ-аас одоо тамхины хор уршгийг бууруулах чиглэлээр хийсэн алхмууд дотор хамгийн одоо үр дүнтэй арга нь бол тамхины албан татварыг

бол өсөх явдал байдаг гэсэн ийм судалгаа үр дүн гарсан байдаг.

Энэ үүднээсээ бол бид нар бол тамхины одоо онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх ийм арга хэмжээ авахаар бас оруулж ирж байна. Мөн Тамхины хяналтын тухай хуулиар зохицуулах, одоо асуудлууд нь тодорхойгүй байсан зүйлүүдийг бас зохицуулах чиглэлээр тодорхой хуулийн заалтын томъёоллуудыг оруулж ингэж явж байгаа.

Г.Занданшатар: 82.

Б.Баярболд: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Нийтийн эрүүл мэндийг хангах Монгол хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах замаар нийтийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахаар бол ажиллаж байна аа. Эрүүл мэндийн яамны зүгээс энэ хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг бууруулах чиглэлээр 8 арга хэмжээний төлөвлөгөөг батлаад гаргасан байгаа.

Энэ дээр Эрүүл чийрэг эр хүн эрүүл, Идэвхтэй амьдрал, Хавдрын эсрэг эх хүүхдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, Харилаас сэргийлэх орчны эрүүл мэнд, Халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг бол батлаад гаргасан байж байгаа.

Эрүүл мэндийн яамны зүгээс уг төлөвлөгөө батлагдан гарсантай холбогдуулаад хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үүнд эрүүл, идэвхтэй амьдралыг дэмжих тогтолцооны чиглэлээр бодлого, эрх зүйн орчныг сайжруулах зорилтын 19 үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байгаа.

Тухайлбал, хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн байдалд тохирсон идэвхтэй хөдөлгөөний үндэсний удирдамжийг боловсруулж байна. Мөн хүүхдийг эрүүл бус хүнсний зар сурталчилгаанаас сэргийлэх эдгээр бүтээгдэхүүнийг хэрэглэх, хэрэглээг бууруулах зорилгоор энэ сургуулийн орчинд худалдаалах хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг гаргаж ажиллаж байна. Мөн Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаалаар энэ ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих журмуудыг бол гаргаад ажиллаж байна. Мөн үүнтэй зэрэгцэж энэ хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлүүдийн судалгааг бол тодорхой давтамжтай хэрэгжүүлээд ажиллаж байна.

Тухайлбал энэ хоол хүнсний хүн амын хоол тэжээлийн үндэсний 5 судалгаа хийгдсэн. Энэ жил бид 6 дугаар судалгааны ажлуудыг бол эхлүүлээд ажиллаж байна аа. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бий болгох чиглэлээр бас бид хэд хэдэн ажил хэрэгжүүлээд ажиллаж байгаа. Хэдхэн хоногийн өмнө бол бид улсын хэмжээний Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж байгаа нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудын зөвлөгөөнийг хийсэн. Энэ зөвлөгөөн дээр бид бас нэлээдгүй ажлыг бол тодорхойлон ажилласан байгаа. Өнөөдөр тулгамдаж байгаа асуудлуудын хувьд Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудын хүрэлцээ хангамж дутагдалтай. Нийтдээ өнөөдөр наян хувийн хангамжтай явж байгаа.

80 хувь дотроо бол яг мэргэшсэн нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь

бол дутагдалтай ийм байдал ажиглагдаж байна. Өрхийн эрүүл мэндийн үндэсний төв болон сумын Эрүүл мэндийн төвүүдэд стандартад нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр яг юу юуг хэрэгжүүлж ажиллах вэ гэдэг бол нэлээн тодорхой тусгаад өгчихсөн. Гагцхүү энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн дутагдал байна. Энэ гарч ирж байгаа. Энэ хүний нөөцийн дутагдлыг нөхөхийн тулд бид бас энэ төгсөлтийн дараах сургалтаар Нийгмийн эрүүл мэндийн ажилтныг мэргэшүүлэх асуудлыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулсан. Нийгмийн эрүүл мэндийн ажилтныг ерөнхий мэргэжлийн чиглэлээр хүний их эмч, уламжлалт анагаах ухаан, нүүр амны чиглэлээр сурсан эмч нараас бэлтгэх үндсэн мэргэжлийн нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төгссөн эмч нараасаа бол энэ нарийн мэргэжлийн хөдөлмөрийн эрүүл ахуй, хүүхэд өсвөрийн эрүүл ахуй, орчны эрүүл ахуй гэсэн энэ мэргэжлүүдийг нарийвчлан бэлтгэх энэ шийдвэрүүдийг гаргаад ажиллаж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар:

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн 1 минут.

Ж.Чинбүрэн: Миний одоо нэг хэлэх гээд байгаа санаа бол энэ нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, заавал мэргэжлийн хүн гэхээсээ илүүтэй тухайн хороодын нийгмийн ажилтнуудыг энэ чиглэлд сургах нь илүү их өгөөжтэй, хүртээмжтэй байна. Иргэн бүрт хүрэх чиглэлд. Энэ чиглэлээр хийсэн ажлууд байна л даа, туршилагууд. Жишээлбэл Хүн амын сантай хамтраад Баянзүрх дүүрэгт

нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр туслах ажилтан гэдэг юм уу тэ, тийм чиглэлээр хороодын одоо идэвхтэй иргэдийг оролцуулах, тэдгээрийг одоо бараг л одоо хороодынхоо иргэдийн эрүүл мэндийн зөвлөх маягаар ажиллуулах энэ үйл ажиллагаа их амжилттай явсан туршилага байна.

Хоёр дахь нэг хэлэх гэсэн санаа бол энэ эрт илрүүлгийн үзлэгийг илж биш илрүүлдэг ийм тогтолцоо руу орох нь их чухал гэдгийг би бол байнга ярьж байгаа. Энэний жишээ бол одоо би өөрөө 2021 онд Баянзүрх дүүрэгтээ 65 наснаас дээш хүмүүсийг хамруулахад хорт хавдрын илрүүлэг 2.7 хувьтай илэрч чадсан байхгүй юу.

Г.Занданишатар: Үг хэллээ тийм хэллээ. Асуулт биш байна. Одоо Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр нийгмийн эрүүл мэндийн асуудал бол одоо хүн ам цөөтэй Монгол Улсын хувьд бол хөгжлийн болон улс орны хүний хүчин зүйлийн хамгийн чухал асуудал байгаа. Тийм учраас энэ асуудал дээр одоо манай Эрүүл мэндийн сайдын бодлого энэ яамны одоо үйл ажиллагаа бол олон нийтэд ил тод, мөн одоо тодорхой асуудлаар шинэ санаачилга гаргах нь их чухал байгаа. Тийм учраас өнөөдрийн санал асуулгад 3 асуултыг энэ Эрүүл мэндийн сайд болон яамны бодлогоос тодруулмаар байгаа юм.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн одоо 2.1.5-д нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хууль эрх зүйн орчныг бий болгоно оо гэсэн байгаа. Тэгэхээр энэ заалтын дагуу одоо энэ Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд Эрүүл мэндийн яамнаас одоо ямар салбарын хууль тогтоомж шинэ

юуг өргөн барих вэ, Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн одоо төсөл маань бэлэн болсон уу, үгүй юу?

Хоёр дугаар асуулт нь ер нь одоо хүн ам эрүүл байх, эрүүл мэндийн боловсрол олгох, өвчнөөс урьдчилан сэргийлэх, энэ одоо дадал зан үйлийг бий болгох нь энэ яамны бол нэг том, одоо чухал зорилт байгаа.

Тэгэхээр энэ чиглэлээр яг санаачлан хийж байгаа ямар ажлууд байна аа? Ер нь бол Монгол Улсын Засгийн газар бол одоо энэ нийтийн биеийн тамир, эрүүл аж төрөх ёсонд анхаарлаа хандуулж, анх удаагаа одоо спорт, нийтийн биеийн тамир хариуцсан сайдтай болсон. Тэгвэл энэ одоо сайдын одоо яг хамтран ажиллахын гол салбар бол энэ Эрүүл мэндийн яам байх ёстой. Яам энэ тал дээр ямар санал гаргаж байгаа вэ?

Гуравт нь энэ зар сурталчилгааны тухай хуулийн тодорхой заалтууд, тэр дотроо одоо эрүүл мэндийн салбарын зар сурталчилгааны заалтууд ер нь амьдрал дээр хэрэгжихгүй байгаад байна. Тухайлбал одоо эмийн бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, тодорхой витаминууд гэх мэтээр эдгээрийн зар сурталчилгааны үйл ажиллагаанд хуультай зөрчилдсөн гэдэг юм уу, одоо зар суртлыг хориглосон тодорхой одоо ийм юмнууд яваад байна.

Жишээлбэл одоо хэвлэл мэдээллийн үндсэн сувгууд, телевиз, радио сонин дээр нь нийгмийн сүлжээний сувгууд дээр тодорхой эмийн бүтээгдэхүүн, нэмэлт бүтээгдэхүүн мөн тодорхой эмнэлгүүдийн сурталчилгаанд яг хуулиар хориглосон зүйл нэлээд орж байна. Жишээлбэл, энэ зөвхөн

эмнэлгийн нөхцөлд хэрэглэх ийм үйлчилгээ, эм бүтээгдэхүүнийг сурталчлах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл аваагүй эмч ажилтнууд тухайн одоо эрүүл мэндийн бүтээгдэхүүн, эмийн бүтээгдэхүүнийг олон нийтэд дамжуулах зэрэг ийм ажлууд бол байнга явагдаж байна. Тэгээд ер нь эмнэлгийн байгууллагын зар сурталчилгаа чинь зөвхөн тухайн эмнэлгийн одоо байршлыг заагаад л, нэрийг нь заагаад зогсох ёстой байтал үр дүнг нь гэдэг юм уу эсвэл янз бүрийн байдлаар одоо хуулиас давсан ийм юм хийж байна.

Тийм учраас одоо нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр эрүүл мэндийн сөрөг үр дагавар гэдэг юм уу тухайн лиценз аваагүй эмнэлгүүдээр үйлчлүүлээд өчнөөн хүмүүсийн гомдол, хохирлууд нэлээн байна. Энэ тал дээр хуульд өөрчлөлт оруулах эсвэл энэ тал дээр Эрүүл мэндийн яам маань ямар бодлого барин ажиллаж байна.

Г.Занданшатар: 81.
Сэрээжавын Энхболд Эрүүл мэндийн сайд.

С.Энхболд: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Нийтийн эрүүл мэндийн тухай хууль Засгийн газраар орж дэмжигдээд одоо өргөн Их Хуралд өргөн барихад бол бэлэн болсон байгаа. Сарангэрэл гишүүний ажлын албанд бол бид бүхэн хүлээлгэн өгсөн. 7 сард өгсөн байгаа.

Хоёр дахь асуулт бол биеийн тамир хариуцсан сайдтай болсон. Бид бүхэн Биеийн тамир, спортын үндэсний хороотойгоо хамтраад, ялангуяа энэ дасгал хөдөлгөөн, эрүүл мэндэд ямар ач холбогдолтой чиглэлээр үе шаттай ажлуудыг

төлөвлөөд одоо энэ ирэх оны 1 сараас эхлэн ингээд сар болгон нэг давтамжтай ийм аянууд өрнүүлэхээр төлөвлөгөөнд ороод тусгагдаад ажлын хэсэг гараад бэлтгэл ажлууд хийгдээд явж байгаа. Яг энэ биеийн тамир одоо хувь хүний бас хариуцлага энэ дээр бол маш чухал.

Тийм учраас бас яг иргэн рүү чиглэсэн ийм нөлөөллийн ажлуудыг бас бид бүхэн бол бусад Төрийн бус байгууллага болон энэ хамтран ажилладаг байгууллагуудтай бол хийж байгаа. Мөн жишээ нь одоо цахим эмчээс авхуулаад ер нь бүх шатны энэ инфлюзер хүмүүстэйгээ бол хамтарч бид нарын нөлөөллийн ажлуудыг бол үе шаттай, тогтмол байнга явуулж хийдэг.

Гуравт яг таны саяын хэлсэн бол яалт ч үгүй энэ хууль тогтоомж дээр бас хэтэрсэн зарим нэг сурталчилгааны ажлууд явж байгаа. Жишээ нь одоо өнгөрсөн 2 сарын хугацаанд эмчилгээтэй асуудал гарсан.

Энэ бол манай улсад удирдамж байдаггүй, стандарт байхгүй. Энийг бол зөвшөөрдөггүй.

Тийм учраас бид нар энэ чинь Мэргэжлийн хяналтын байгууллагатайгаа хамтарч энэхүү асуудлыг бас шийдвэрлэж, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байгаа. Мөн Нийслэлийн эрүүл мэндийн газраас бас нэлээн эмнэлгүүдэд бас зөвшөөрөл өгдөг. Энэ чинь бас тодорхой хэмжээний хяналт, цензур тавьж байж бас өгөгддөг байгаа.

Тийм учраас энэ ялангуяа Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтарч энэ байнгын одоо энэ эрүүл мэндийн байгууллагууд явж байгаа. Дээрээс нь энэ хэвлэл мэдээллээр явж

байгаа зарим эм болон ялангуяа эмийн био нэмэлт бүтээгдэхүүн дээр бол эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар бол Байнгын хяналт тавьж байцаагч нар бол ажилладаг. Одоо энэ ирэх оны 1 сарын 1-нээс эхлэн Мэргэжлийн хяналтын байгууллага бас татан буугдаж байгаатай холбоотой манай дээр бас нэг тусдаа газар байгуулагдана.

Тийм учраас одоо бид бүхэн бол энэ дээр тогтмол хяналтыг тавьж сайжруулах чиглэлээр ажиллана. Мөн дээрээс нь одоо ирэх оны 1 сарын 1 гэхэд Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль, ЭМД-ын тухай хуулийг бас шинэчлэн найруулахаар төлөвлөгөөнд орчихсон энэ хуулиуд дээр бас тодорхой заалтуудыг бол тусгаж өгөхөөр ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Нанзадын Наранбаатар.

Н.Наранбаатар: Би бол гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой л зүйл асууя. Та нөгөө Байнгын хорооны хурал дээр нэг одоо үйлчлэгч нар 900 гаруй мянга, жолооч нар сая гаруй, тусгай мэргэжилтнүүд 1 сая 300 гаруй, их эмч нар 1 сая 800-аас 2 саяын цалин авч байгаа гээд хэлчихсэн байсан. Тэгээд тэр мэдээллийг бас би өөрийнхөө одоо сошиал хуудсан дээр тавьсан. Тэгээд манай тойргийн одоо эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд бол бас бодит байдалтай нийцэхгүй байна аа, хэтэрхий одоо өндрөөр хэлсэн байна гэдэг асуудал ярьсан. Би бас одоо өөрийнхөө аймгийнхаа Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн даргатай бас холбогдож ярьж байгаа. Цалингийн хувьд бол бас доогуур байгаа. Хамаагүй доогуур байгаа. Гүйцэтгэлийн санхүүжилт гэдэг

систем рүү орсноос хойш одоо бид бас цалингаа дорвитой нэмж чадахгүй байна.

Тухайлбал, 9 дүгээр сарын санхүүжилтээс 40 хувь дутуу, 10 дугаар сарын санхүүжилтээс 40 хувь дутуу гээд ингээд гүйцэтгэлээсээ ирж байгаа санхүүжилт нь дутуу хүрээд ирэхээр энэ байгууллага чинь цалингаа нэмэх нь битгий хэл цаашаа өрөнд ороод ингээд яваад байх юм. Тийм учраас та бүхэн одоо энэ гүйцэтгэлийн санхүүжилтээ ялангуяа 2, 3 дугаар шатлалын эмнэлгүүд дээр одоо хэрхэн яаж зохион байгуулж өгөх юм бэ? Энэ чигээрээ цаашаа ингээд яваад байвал өр ширэндээ баригдаад энэ эрүүл мэндийн байгууллагууд бас ажиллах хүнгүй болох гээд ажлаасаа маш олноороо гарах байдал руу орчихоод байгаа юм.

Энэ дээр ямар одоо тодорхой арга хэмжээ авах юм бэ гэдэг нэг ийм асуудлыг асууя.

Хоёр дахь асуулт нь бол энэ Цагаан хадан дээр хийгдэж байгаа энэ PCR шинжилгээг ХӨСҮТ-ээс очоод хийгээд байгаа шүү дээ. Тэгээд аягүй их хэл ам гараад байна. Энэ боомтын чиглэлээр гарсан Хяналт шалгалтын түр хороо ч сая хоёр өдрийн өмнө хуралдсан. Тэгээд энэ дээр одоо авлигын асуудал их яригдаад, өнөө бөмбөлгийг хагалдаг барьдаг асуудал өмнө нь ч би бас энэ асуудлаар та бүхэнд хандаж л байсан. Тэгээд тийм юм байхгүй гэсэн л хариу ирээд байсан. Тэгээд энэ чинь ингээд байсаар л байгаад байх юм аа, их түвэгтэй асуудал юм. Энийг энэ манай Бүсийн оношилгоо, эмчилгээний төв рүү шилжүүлээд өгч болдоггүй юм уу? Аймаг руу нь. Манайд бол одоо энийг нь хийчих тоног төхөөрөмж, хүний нөөц, зарим дутагдалтай ганц нэг хүнийг

мэргэжилтнийг бол гэрээгээр аваад ажиллуулчих бас боломж байгаа. Тэгэх юм бол эндээс чинь бол маш их хэмжээний төлбөр хураамж, орлого төвлөрч байгаа шүү дээ. Энийг нь шилжүүлээд өгчих юм бол бас тодорхой хэмжээгээр Бүсийн оношилгоо, эмчилгээний төв маань бас асуудлаа шийдэх ийм бас боломж нөхцөл байгаа гэсэн нэг ийм асуудал байна.

Гурав дахь нь цаашидаа энэ боомтууд дээр ер нь эмч, эмнэлэг одоо ажиллуулах ямар боломж байна? Маш их хэмжээгээр хүмүүс оччихсон.

Г.Занданшатар: 81.
Сэрээжавын Энхболд Эрүүл мэндийн сайд хариулъя.

С.Энхболд: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Энэ 7 хоногт болсон байнгын хорооны хурал дээр бол бид нар нийт салбарын дундаж дундаж тоог бол хэлсэн байгаа. Бид нарт сум, аймаг лавлагаа шатлал болон эмнэлгүүдийн гаргасан энэ хүснэгт бол бид нарт байгаа. Ялангуяа энэ дээр Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв дээр бас удирдлагын асуудалд нэлээн хүндхэн яригдаж байгаа.

Энд эмнэлгийн бас зохион байгуулалт хийж, зохион байгуулалтад орж одоо бас энэ тусламж үйлчилгээн дээрээ анхаарахгүй бол бас дийлэнх хүмүүсээ хувийн хэвшил болон бусад төв рүү явуулах ийм үзэгдэл нэлээн байгаа.

Тийм учраас энд гүйцэтгэл бас төдийлөн сайн гарахгүй байх шиг байна. Танд би энэ цалингийн хүснэгтийг нь бас бичгээр өгчихье.

Энэ дээр бас бид нар дэлгэнгүй тодорхой байгаа. Энийг одоо бүгдийг нь унших боломжгүй байгаа учраас. Энэ дээр нэг юм хэлэхэд 3 сарын 8, 9-ний Засгийн газрын 107 дугаар тогтоол гарсан. Энэ маань өөрөө шууд автоматаар бүх энэ эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа ажилчдын цалин бол автоматаар 8 хувь нэмэгдэж бодогдож байгаа гэсэн үг өссөн. Мөн дээрээс нь байгууллагууд өөрсдөө гүйцэтгэлийнхээ санхүүжилт дээр суурилоод үндсэн цалингаа бас дахиж нэмж байгаа. Энэ өнгөрсөн 8 сарын хугацаанд нийтдээ эрүүл мэндийн салбарын албан байгууллагууд 10-50 хувь хүртэл нэмсэн байгаа. Ялангуяа орон нутгууд маань бол 10-20 хувь хүртэл бол нэмсэн.

Өмнөговь аймагт ч гэсэн бас 10 хувиар нэмсэн байгаа юм. Тэгэхээр энэ маань одоо өмнө нь авч байсан цалингаас бол тодорхой хэмжээнд цалингууд бол нэмэгдсэн.

Дээрээс нь нэг юм хэлэхэд ялангуяа энэ гүйцэтгэлээр санхүүжиж байгаа энэ хугацаанд жил гаран хугацаанд бид нар энэ хуулийг хэрэгжүүлээд явж байх хугацаанд бол бусад салбараас манай салбар ганцаараа энэ цалингийн тогтолцоогоо бол нэмсэн салбар байгаа. Энэ бол маш том энэ гүйцэтгэлийн санхүүжилт, энэ хуулийн хэрэгжилт бол маш сайн явж байгаагийн илрэл гэж үзэж байгаа.

Хоёр дахь асуултыг Цагаан хадан дээр энэ лабораторийн PCR шинжилгээтэй холбоотой маш олон одоо асуудал гарч хууль хяналтын байгууллага шалгасан. Энэ дээр одоо ганц үүсээд байгаа асуудал бол ерөөсөө л тэр эдгэсэн хүмүүсийн шинжилгээ одоо өвчлөөд эдгэрсэн хүн дээр бол

ээрэг гардаг тохиолдлууд байгаа. Энэ дээр л маш их хэл ам үүсэж байгаа. Түүнээс биш яг Халдвар судлалын үндэсний төвөөс мэдээж энэ авлига юу асуудал ихтэй учраас бид нар 14 хоног тутам энэ ээлжийг дандаа сольдог. Бүсийн оношилгооны төвд бол бид нар бас энийг энэ лабораторийн шинжилгээг бол хариуцуулж өгөхөөр шийдвэрийг бол удаа дараа бичиг явуулсан. Харамсалтай нь одоо тэр яг Цагаан хадан дээр барьж байгаа штабаас бол мэргэжлийн байгууллага нь ажиллаж байгаач ээ. Ирэх оны 1 сарыг хүртэл ажиллаач гэсэн тийм хүсэлтийг тавьсан учраас ХӨСҮТ тэнд ажиллаад байгаа юм.

Тэгвэл одоо бид нар тэр Бүсийн эмчилгээ оношилгооны төвийн ажилтнуудыг чадавхжуулсан, мэргэшүүлсэн, тийм байгаа.

Дээрээс нь энэ ялангуяа боомтууд дээр бид нар энэ явуулын эмнэлгүүдийг суурилуулж эхэлсэн байгаа. Мөн Цагаан хадан дээр бол мэдээж хүн ам төвлөрсөн нэлээн суурьшин хөдөлгөөнт бүс мөртөө илүү тийм хүн ам төвлөрсөн газар тэндээ, бас хэд хэдэн хувийн хэвшлийг хамтарч эмнэлэг байгуулья гэсэн. Тэрэн дээр нь бол бид нарт дэмжлэг үзүүлээд явж байгаа.

Г.Занданшатар: Нанзаддын Наранбаатар гишүүн тодруулж, асууя. 1 минут.

Н.Наранбаатар: Энэ 2, 3 дугаар шатны эмнэлгүүдийн одоо нөгөө зохион байгуулалтын хэлбэр нь ТУЗ-тэй болоод, ингээд цаашаа ТУЗ нь одоо нөгөө гүйцэтгэх удирдлагыг нь сонгон шалгаруулж явна гээд яригдаад байгаа шүү дээ. Энэ асуудал ер нь яаж явж байгаа вэ? Улсын хэмжээнд яаж явж байна вэ? Хэр хэрэгжилттэй явж

байна вэ гэдэг талаар товчхон мэдээлэл.

Г.Занданшатар: 81.
Сэрээжавын Энхболд сайд хариулья.

С.Энхболд: ТУЗ-тэй холбоотой Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бас албан тоотууд тогтоолууд гарсан. Үүнтэй уялдуулж бид нар бас энэ хуульд туссан учраас энэ ТУЗ байгуулах чиглэлийг холбогдох аймаг болон нийслэл рүү бол хүргүүлж, энэ үе шаттай хийгдээд явж байгаа. Одоогийн байдлаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс Өвөрхангай Орхоных хийгдэж байна.

Өвөрхангай аймгийнх бол бүрэн томилогдчихсон. Тэгээд үе шаттай хийгдээд тухайн орон нутгийн Засаг дарга бас энд өөрөө манлайлж ажиллах ёстой. Дүүргийн хувьд бол дүүргийн Засаг дарга бас энд оролцох ёстой. Бид нар өөрсдөө хамгийн гол нь тэр ажлын хэсэг үнэлгээнийхээ багийг гаргаж, Эрүүл мэндийн яам зөвлөн туслах, дэмжих зорилготойгоор л ажиллаж байгаа. Чиглэлүүд нь бол хүргэгдчихсэн. Эхнээсээ байгуулагдаад явж байгаа гэсэн үг.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүний хувиар өнөөдөр аюулын хэмжээнд хүрээд байгаа, нэлээн ноцтой хэмжээнд хүрээд байгаа нийгмийн эрүүл мэндийн асуудлаар бодлого тодорхойлж байгаа сайдад маш тодорхой 7 асуултаар асуулга тавьсан.

Надад 25 хуудас мэдээлэл ирүүлсэн боловч энэ одоо мэдээлэлд тодорхой үр дүн, бодлого гэхээсээ илүүтэйгээр статистик тоо

баримтуудыг илүү их ингээд бичээд явуулжээ. Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар бид тодорхой хэмжээний төсөв жил бүр баталдаг ба үүнийхээ гүйцэтгэл, үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын чиглэлийг илүү их сонсоно гэж одоо бодож хүлээж байсан боловч сэтгэлд хүрсэнгүй. Түүрүүн бас гишүүд хэлж байна. Эрүүл мэндийн салбар таны толгойлж байгаа салбар бол яг 2 үндсэн чиг үүрэгтэй. Нэг нь эмнэлгийн тусламж үйлчилгээ, нөгөөдөх нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл өвчтэй хүмүүстээ эмнэлгийн тусламж үйлчилгээ эрүүл байгаа иргэдээ илүү эрүүл мэндийг нь илүү сайн болгох, Монгол Улс үндэстнийг, иргэдийг эрүүл байлгах ийм одоо үндсэн чиг үүрэгтэй байгаа.

2021 онд улсын төсөвт 1.9 их наяд төгрөг эрүүл мэндийн салбарт зарцуулагдсан.

Үүнээс 158.2 тэрбум төгрөгийг нийгмийн эрүүл мэндийг сайжруулах асуудалд энэ төсөв зарцуулагдаж байгаа. Энэ дээр нэмээд та бүхэн ЭМД-ын сангаасаа эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ гэж нэрлээд 60 тэрбум төгрөг зарцуулж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Тэгээд өнөөдөр энэ одоо эрт илрүүлгийн чинь ажил бол үнэндээ үр дүнтэй явагдахгүй байна. Та бүхний өгсөн мэдээлэлд 500000 гаруй хүн эрт илрүүлэгт өнөөдрийн байдлаар хамрагдчихсан байна. Үүний 70 хувь нь буюу 330000 хүн нь хүүхдүүд байна. 0-17 насны хүүхдийн үзлэгт хүүхдийн биеийн индекс жин гэдэг юм уу сэтгэл зүй, зан үйл, сүрьеэгийн эрсдэлийн үнэлгээ, биеийн өсөлтөө ингээд хэмжээд байгаа боловч хүүхдийн хавдар эрс нэмэгдэж байгаа энэ үед хүүхдийг нарийн шинжилгээнд ерөөсөө хамруулахгүй байна.

Шүдний эмчилгээ, үйлчилгээнд хамруулахгүй байна. Тэгээд энийгээ яагаад ингэж ор нэр төдий явуулаад байгаа юм бэ гэдэг ийм асуудал байна. Энэ одоо эрт илрүүлэг удааширалтай байна гэдгийг олон удаа хэлж байгаа. Жишээлбэл Улаанбаатар хотын 30000 иргэдтэй нэг хороон дээр өдөрт ерөөсөө 10 хүрэхгүй хүн эрт илрүүлгийн шинжилгээнд оролцоод байна. Энийг одоо яг энэ өдөрт үзүүлж байгаа хүмүүсийг Монгол Улсынхаа хүн амтай ингээд тооцоод үзэх юм бол та бүхний эрт илрүүлгийн энэ ажил чинь хорин хэдэн жил үргэлжлэх гээд байгаа байхгүй юу?

Тэгэхээр энэ ажлаа яаж одоо эрт гэж байгаа юм бол? Хурдхан дуусгах юм бэ? Яаж үр дүнтэй хэрэгжүүлэх юм бэ гэдэг асуудал байгаад байна. Хөдөө орон нутагт энэ хэрэгжих боломжгүй байгаа гэдгийг би та бүхэнд удаа дараа хэлж байгаа.

Жишээлбэл, манай Завхан аймгийн.

Г.Занданшатар: 81. Сэрээжавын Энхболд сайд хариулъя.

С.Энхболд: Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

158 тэрбум гэдэг маань ноднингийн төсвийн тодотголоор тавигдсан төсөв бол 238 тэрбум төгрөг нийтдээ төсөвлөгдсөн.

Үүнээс 110 тэрбум нь цэвэр тоног төхөөрөмж буюу ялангуяа энэ гүйцэтгэлийн санхүүжилтээр явж байгаа энэ үед орон нутгуудыг бас тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж чадавхжуулж, энэхүү гүйцэтгэлийн санхүүжилтийн үед нэг гараанаас эхлэх ийм боломжийг

олгосон. Тийм учраас энэ бол дандаа тоног төхөөрөмжийн худалдан авалтууд хийгдсэн. Би түрүүн бас яг товч танилцуулга дээрээ хэлсэн.

20 аймаг, 5 дүүрэг, 3 сум дундын эмнэлэг гэдэг маань нийтдээ 38.5 тэрбум төгрөгөөр бид нар дэмжих төвийг бий болгосон. Ингэж байж бид бүхний одоо энэ 5 сарын 1-нээс эхэлсэн энэ эрт илрүүлэг, үзлэг оношилгоо, шинжилгээ маань явж байгаа. Шууд дангаараа хуучин байсан бүтэц дээр бол энэ эрт илрүүлэг, үзлэг оношилгоо шинжилгээг хийх бол ямар ч боломж бололцоо байхгүй. Тийм учраас бид нарт нэмж дэд бүтцийг бүрдүүлж, ялангуяа амбулаторийн тусламж үйлчилгээнээс тусдаа нэг цэгийн үйлчилгээ шиг тийм хэсгийг байгуулж, 20 кабинетыг иж бүрэн тохижуулж, 2020 оноос эхлэн бид нар бол энэ үйл ажиллагааг эхлүүлсэн. Энэ үе удаагийн энэ эрт нэвтрүүлэг, шинжилгээнд бол шинжилгээний нэр төрлийг бол нэмэгдүүлсэн байгаа. 0-17 насанд бол 5-6 нэр төрөл. Энэ бол ялангуяа тухайн өвчлөл, статистик тоон мэдээн дээр суурилж бид нар бол энэ 5-6 нэр төрлийн шинжилгээг хийсэн. 18-аас дээш насанд бол бид нар 12-19 нэр төрлийн шинжилгээг бол өргөтгөсөн байдлаар хийсэн. Энэ маань өөрөө ялангуяа бас яг энэ зонхилон тохиолдож байгаа өвчлөл аль өвчлөл нь илүү тохиолдож байгаа учраас тэр рүү чиглэсэн ийм шинжилгээний багцыг нэмэгдүүлж баталж байж гаргасан. Тэгээд 2022 онд бол бид нар энэ эрт илрүүлэг шинжилгээнд хамрагдах ЭМД-ын сан дээр 60.8 тэрбум төгрөгийг бол төсөвлөсөн. Өмнөх 2018 оноос хойш бол дандаа 20 тэрбум төгрөг, тэгэхдээ гүйцэтгэл бол төдийлөн өндөр байгаагүй. Энэ маань одоо тухайн шинжилгээний нэр төрөл бага байсан. Цөөн тоотой байсан.

Дээрээс нь ялангуяа яг энэ шинжилгээг хийх дэд бүтэц нь бүрдээгүй байсан учраас хамрагдалтын хувь бол маш бага. Хамгийн өндөр хамрагдсан жил нь бол 2019 он байдаг. 153000 хүн хамрагдсан байдаг.

Тэгэхээр бид нар одоо энэ жилийн хийж байгаа онцлог бол энэ насны багцуудыг нэмсэн шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлж хийгдэж байгаа. Ингэж байж одоо бид бүхний одоо энэ бас ялангуяа маш том өвчлөлийн дата гарч ирнэ. Нийтийн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлийн ажлууд бас давхар хийгдэж байгаа.

Дээрээс нь энэ чинь нийтийн эрүүл мэндийн чиглэлийн маш том бодлогын бичиг баримтууд дээр үндсэн өөрчлөлт хийх суурь дата болж өгнө гэсэн ийм зорилготойгоор энэ ажлуудыг бол хийгээд явж байгаа гэдгийг хэлье.

Хүүхдийн хорт хавдрын чиглэлээр бол жилдээ манайд 130-150 хүүхэд бол жил бүр оношлогддог. Энэ рүү чиглэсэн скрининг шинжилгээнүүд бол тусдаа хийгддэг. Ялангуяа бид нарт одоо эхийн хэвлийд байхаас нь авхуулаад энэ удам зүйн лабораторийг бол үе шаттай байгуулж явж байгаа. Одоогийн байдлаар 3 эмнэлэг дээр байгуулсан. Энд бас хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэх, бэлтгэх ажил нь бол цуг хийгдэж, ялангуяа энэ эрт үед нь оношлох эмчилгээ оношилгооны аргуудыг илүү нэвтрүүлэх чиглэлээр ажлууд хийгдэж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууна.

Б.Баярсайхан: Нийгмийн эрүүл мэндийн асуудлыг ярихаар 22 тэрбум төгрөгөөр барьсан, энэ аймаг болгонд барьсан гээд байгаа энэ нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвийг яриад байх юм аа. Олон улсын жишгээр болохоор энэ нийгмийн эрүүл мэндийг сайжруулах зорилготой энэ Эрүүл мэндийн төв нь үзлэг оношилгоо ерөөсөө хийдэггүй ээ, илүү одоо сургалт, ухуулга, амьдралын зөв хэв маяг хэвшүүлэх, эрүүл хооллолт, шим тэжээлийн зөвлөгөө гэдэг юм уу соён гэгээрүүлэх ажлыг хийдэг шүү дээ.

Тэгээд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэн сайдыгаа одоо энэ мэргэжил арга зүйгээр нь хангаж, энэ төвийг яг зөв ажиллуулахад нь та бүхэн одоо өөрсдөө ажлаа хийгээч ээ. Яагаад энэ 1.9 их наядын төсвийнхөө 85 хувийг эмнэлгийн тусламж үйлчилгээндээ зарцуулаад байгаа байж байж дахиад нийгмийн эрүүл мэндийн салбараа үзлэг шинжилгээний газар болгох гээд байгаа байгаа юм бэ гэдэг асуудал дээр бол үнэхээр санаа зовж байна аа?

Өөрөөр хэлбэл өртөгтэй үзлэг хийгээд эргүүлээд та бүхэн эрүүл мэндийн салбар эрүүл мэндийн нийгмийн даатгалаасаа мөнгө аваад байна шүү дээ.

Г.Занданшатар: 82.

Б.Баярболд: Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

ДЭМБ-аас нийгмийн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай 10 тусламж үйлчилгээг тодорхойлж гаргасан байдаг. Үүнийг 5 дугаарт өвчнийг эрт илрүүлж оношлох асуудлыг бол тусгаж өгсөн байгаа. Тэгэхээр нийгмийн эрүүл мэндийн асуудлын нэг томоохон хэсэг нь бол

эрт илрүүлэг, үзлэг оношилгоо, шинжилгээ байгаа. Өнөөдөр бид бас энэ эрүүл мэндийг дэмжих төв бол өөрөө нийгмийн Эрүүл мэндийн төв биш тусдаа эрүүл мэндийг дэмжих, онолох төв байгаа. Аймгуудад бол аймгийн эрүүл мэндийн газарт Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс б аймагт нийгмийн Эрүүл мэндийн төв ажилладаг. Эдгээр төвүүдээрээ дамжуулж энэ эрүүл мэндийн сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлуудыг бол хийдэг байгаа. Хариулж дууслаа.

Г.Занданшатар: 85. Уг нь 1 минутанд л багтааж хариулах ёстой.

Ж.Нарангэрэл: Гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Нарангэрэл эмнэлгийн тусламжийн газар. Яамны баг бүрэлдэхүүн бол энэ хэлп пормушин центр, хэлп скрининг центр гэдэг ойлголтын хувьд бол судалж үзсэн. Анх энэ юугаа гаргахдаа бол. Ингээд одоогийн нөхцөл байдал Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн байдалд хожуу оношлогдох хавдрын тохиолдолд аливаа өвчний дандаа 2, 3 дугаар үе шат руу байсан тохиолдол байгаа. Энийгээ бид бүхэн эхний хамгийн түрүүнд бол онолох ёстой. Энэ оношилгоонд таарсан зөвлөмж өгөх ёстой гэдэг утгаараа энэ маскрининг эхэлсэн байгаа. Энэ дэмжих төв гэдэг байдлаар байгуулагдсан төв дээр маань эрт илрүүлгийн бүх шинжилгээ, оношилгоонууд явагдахаас гадна сүүлийн юунд нь мэргэжлийн эмч мэргэжилтнүүд зөвлөгөөг нь өгөөд гаргаж байгаа. Тэгэхээр энэ бол таны ярьж байгаа юутай бас дүйж байгаа байх гэж бодож байна. Гэхдээ бас хэл пормушин центр гэдэг ойлголтыг бид бүхэн мэдэж байгаа. Энэ чиглэл илүү нийгмийн эрүүл мэндийн тусламж

үйлчилгээг нэмэх энэ ойлголт байгаа гэдгийг л бас ойлгож байгаа. Хүүхдийн хавдрын чиглэл дээр бас танд нэмэлт мэдээлэл өгөх гэсэн юм. Энэ хүүхдийн олон улсад бас энэ хүүхдийн одоо хүүхдийн скрининг дээр юу байдаг юм бэ гэдгийг бид бүхэн бас анх энэ үйл ажиллагаа эхлэхэд судалгаа хийж байгаад хөгжсөн улс орнууд тэр дундаа нийгмийн тусламж үйлчилгээ илүү одоо хөгжчихсөн улс орнууд болон одоо хөгжиж байгаа улс орнууд дээр ямар скрининг хэрэгтэй байдаг юм бэ? Өөрөө улс орныхоо хүүхдийн одоо бас өвчлөлийн түвшнийг хараад энэ юуг багцыг гаргасан байгаа.

Энэ хүүхдийн одоо оношилгоон дээр бол олон улсад яадаг вэ гэхээр дандаа энэ анхны гаргасан ба багцаар хийгээд үүнээсээ цаашаа одоо оношилгоогоо лавируулах байдлаар, жишээлбэл биеийн жингийн индекс өндөртэй байхад бол бодисын солилцооны эмгэгийг сэжиглээд цааш нь шилжүүлэх маягтай байгаа.

Хавдрын тохиолдол дээр бол манай хүүхдүүдийн дотор 6 төрлийн хавдар зонхилоод байгаа. Энэ хавдрууд бол яг энэ одоо скринингээр бол өөрөө скринингээр эрт барьж авахад хэцүү байдаг. Энийг бол мэргэжилтнүүд ч бас зөвлөж байгаа. Эндээс хамгийн түрүүнд бид нар цусны энэ хорттой хавдрын тохиолдол байгаа. Энэ нь нэг удаагийн скринингээр бас оношлох боломжгүй л дээ. Тэгэхээр таны хэлж байгаа юугаар эрт илрүүлэх скрининг рүү бүх хүүхдийг хавдрын скрининг оруулах боломжгүй байгаа юм.

Тийм тусдаа системээр явах ёстой ийм шаардлагатай одоо эмгэг байгаа юм.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр яах аргагүй энэ хүний хөгжлийн суурь асуудал нь эрүүл мэндийн асуудал. Тэгэхдээ манай эрүүл мэндийн салбарынхан, эмч мэргэжилтнүүд энэ хүнд цаг үеийг бол амжилттай давцгаасан. Тэгэхээр бид нар нэг ийм давагдашгүй хүчин зүйлтэй тулаад тэр лүү гол анхаарал төвлөрөөд, бусад эрүүл мэндийн асуудлууд яаж явж вэ гэдэг юмаа харах гээд би тэр эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг улсын хэмжээнд эхлүүлчихлээ гэж ингэж ойлгосон. Энэ ажлын явц яг одоо хэдэн хувьтай байна аа? Тэрүүгээр ер нь юу өгүүлэгдэж гарч ирж байна вэ? Энэ иргэдийн чинь эрүүл мэндийн байдал ер нь ямар байна гэж одоо урьдчилсан төлөв дүгнэлт гарч ирж байна вэ? Түүний мөрөөр ямар арга хэмжээ авах гэж байна вэ гэдэг асуудал байгаад байгаа юм.

Хоёр дахь асуудал. Бид бол нэлээн онцлогтой улс орон шүү дээ. Нэлээн тархай дуу байршигчсан. Нүүдлийн соёл иргэншил нэлээд давамгайлчихсан ийм улс орон.

Тийм учраас энэ эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг тэр нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирынх нь арга зүйч чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа юм уу? Бид нар. Энүүнийг л бид орхигдуулчихаад байгаа юм шиг байгаа юм, яг нарийндаа. Тэгэхээр одоо энэ шинэ сайд, эрүүл мэндийн сайд 2 бол яах аргагүй нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирын чиглэлээр хавсарсан хөтөлбөр гаргаж, энэ ард түмнийг эрүүлжүүлэх, эрүүл аж төрөх зан үйл, тэр юм руу нь чиглүүлэх арга хэмжээг авах ёстой, би бол тэгж боддог. Тэр битгий хэл тэр ХБХБ тэмдгийн нормыг сэргээх ёстой байхгүй юу? Ямар насандаа ямар

хэмжээний тийм чадамж өөртөө бүх хүн шингээсэн байх ёстой юм? Тэгж байж тэрүүгээрээ дамжиж тэр эрүүл байх үйл явц нь дэмжигдэж хангагдаж явах ёстой байхгүй юу. Тэгээд ийм юмнуудыг ер нь та нар юу гэж бодож, яаж хийж байна вэ?

Эрүүл мэндийн салбар дээр дараагийн нэг асуудал бол боловсон хүчний хангалтын асуудал. Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн хангалт өнөөдөр яг хэдэн хувьтай байгаа вэ? Цаашид энэ хөдөөгийн эрүүл мэндийн тэр тусмаа энэ анхан шатны эмнэлгийн байгууллагуудыг яаж энэ эмч эмнэлгийн боловсон хүчнээр хангана гэж тооцож байна вэ? Энэ дээр ямар бодлого чиглэл хэдүүлээ хэрэгжүүлэх ёстой вэ гэдэг асуудал байна аа? Энийг нэг тодруулж, одоо хариулт авах шаардлагатай байна.

Дараагийн нэг зүйл бол яах аргагүй энэ цаг үе өөрөө энэ технологи дээр тулгуурлагдсан зуун юм. Бүх салбарт энэ нэвтэрчихлээ. Тийм учраас бид нар нотолгоонд суурилсан оношилгооны тухай асуудал их яригдаж байна. Тэгэхээр энэ анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын чинь тоног төхөөрөмжийн хангалт стандартыг бид нэг шинэчилсэн тэр ер нь амьдралд хэр нийцэж байгаа вэ? Ер нь ямар.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? 81. Эрүүл мэндийн сайд Сэрээжавын Энхболд.

С.Энхболд: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ эрт илрүүлэг, үзлэг, оношилгоо, шинжилгээг бол 5 сарын 1-нээс эхлэн иргэн бүрийг жилд нэг удаа хамруулах зорилгоор маш том зорилтыг тавьж ажилласан. Бид яг өнөөдрийн байдлаар 542800 гаран хүн бол энэ шинжилгээнд

хамрагдсан байгаа. Үүний 52 хувь нь бол Улаанбаатар, 48 хувь нь бол орон нутагт хамрагдсан байна. Ялангуяа орон нутагт одоо сумдын маань алслагдсан сумдуудаас хамрагдалт бас төдийлөн сайн биш байгаа. Хамгийн гол нь эрт илрүүлэг, үзлэг шинжилгээг бид нар яах гэж чиглэсэн гэхээр нийт одоо манайд энэ бас өвчлөл бас нэлээн өндөр тэргүүлэх 5 өвчлөлөө бид нар бас их гол юуг бол барьсан. Энэ маань өөрөө ялангуяа энэ иргэдийн насжилт, дундаж наслалтыг нэмэгдүүлэх эрүүл хүн бүр бий болгох зорилготой маш том зорилтыг тавьж энэ ажлыг эхлүүлсэн байгаа. Энэний хүрээнд бас 2 дахь гол зорилго бол ялангуяа энэ ковидын дараах үлдэц, уршиг ямар үлдцүүд байна, тэрийг бас давхар эвдрүүлэх зорилготой энэ шинжилгээнүүдийг бол эхлүүлсэн. Энэ бол харьцангуй бас бид нар бүхний хувьд бол бас өндөр хувьтай явж байгаа гэж үзэж байгаа юм.

Мэдээж, энийг бол жил болгон ингэж төсвийг нэмэгдүүлж, жил болгон эрчимжүүлж явна гэдгийг бас энд бас хэлмээр байна. Бид нар, ялангуяа бас явуулын суурин болон явуулын чиглэлээр энэ үзлэг оношилгоог бол зохион байгуулж байгаа. Мөн төмөр зам дагуух бас иргэдийн суурьшмал бүсүүдэд бид нар вагонд одоо тоногдсон иж бүрэн тийм явуулын амбулаториудыг бол явуулж ажиллуулж байна. Мөн орон нутгуудад бас бүрэн тоноглогдсон автомашинуудыг бас үзлэг оношилгоо, шинжилгээнүүдийг зохион байгуулалттайгаар хийж байгаа үе шаттай. Мэдээж анхан шатны тусламж үйлчилгээ бол манай эрүүл мэндийн салбарын бол хамгийн гол хөдөлгөх хүч. Ялангуяа эндээ одоо бид нар илүү анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах юм бол, ялангуяа дараагийн л лавлагаа шаталт

ирэх ачаалал бас багасна, тэр хэрээрээ илүү одоо чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх боломжууд бас давхар бүрдэх юм байгаа юм.

Тийм учраас 2022 онд одоо нэг иргэний тарифыг нэг дахин нэмсэн. Энэ маань өөрөө одоо энэ анхан шатны тусламж үйлчилгээ болон хүний нөөцийг нэмэгдүүлэх зорилготой алхмуудын нэг гэж үзэж болно. Ингэсний хүчинд бас энэ жил бас анхан шатны байгууллагууд цалингаа бас тодорхой хувиар нэмсэн. Ингэснээрээ одоо хүний нөөц нь бас нэлээн нэмэгдэх ийм хандлага гарч ирж байна.

Дээрээс нь тоног төхөөрөмжийн хувьд бол бас харилцан адилгүй байгаа. Энэ дээр одоо бид бүхэн бол ямар ч гэсэн эхлээд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр явж байгаа төсөл дээр жишиг өрхийн эмнэлэг болон сумын эмнэлгийн загвар барилгын ажлын зургийг бол хийж дуусгаж байна. Тэгээд тийм учраас ирэх жилээс эхлэн бид нар энэ жишиг одоо анхан шатны эмнэлгийн барилга байгууламж ямар байх ёстой юм, энэ норм стандарт нь ямар байх ёстой юм? Энийг бол ингээд үе шаттай гаргаж байгаа.

Дээрээс нь бид нар бас энэ анхан шатны тусламж үйлчилгээний сонгон шалгаруулалтын журмыг бас нэлээн өөрчилсөн. Одоо хэдэн эмчтэй байх ёстой, хэдэн сувилагчтай байх ёстой, ямар ямар тоног төхөөрөмжтэй байх ёстой юм? Ингэж байж илүү одоо тэр анхан шатны тусламж үйлчилгээ маань сайжирна гэж үзэж байгаа. Энэ дээр үе шаттай энэ ажлууд хийгдэж байгаа гэсэн үг.

Дараагийнх нь Буянтогтох хариулчих.

Г.Занданшатар: 87. Өөрийгөө танилцуулаад.

Б.Буянтогтох: Батжаргал гишүүний асуултад Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Буянтогтох хариулъя.

Эрүүл мэндийн хүний нөөцийн асуудлыг хөндлөө. Тэгэхээр манайх төгсөлтийн өмнөх боловсролын асуудал бол Боловсролын яамны харьяанд явдаг эмч, сувилагч бэлтгэх асуудал. Төгсөлтийн дараах нь бол Эрүүл мэндийн яамны харьяа явдаг аа. Тэгэхээр бид саяхан судалгаа хийгээд үзэхэд одоо 2026 он хүртэл төгсөх их эмч, бас сувилагчийн тоо гаргаад үзэхэд жишээлбэл сувилагч бол 2026 он хүртэл бүгдээрээ одоо дундаа завсардахгүйгээр төгслөө гэхэд 4600 байхад эмч бол нэг 7600 орчим эмч төгсөхөөр ийм төлөвтэй байна аа. Сая бид нар бас энэ ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу эмнэлгүүддээ сонгон шалгаруулалт хийгээд үзэхэд төгсөлтийн дараах сургалттай холбоотой асуудлаар ямар асуудал гарч байна гэхээр төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг илүү түлхүү бэлдэх шаардлагатай гэсэн хэрэгцээ шаардлага бол гарч ирж байна. Түүнээс үндсэн мэргэжлээр бол бид нар хангалттай хэмжээний эмч нарыг бол төгсөлтийн дараах сургалтад хамрагдаад ингээд явж байна. Хамруулаад явж байна. Энэ онд хийсэн бид нар хүний нөөцийн талаар хийсэн нэг чухал ажил бол энэ цөм хөтөлбөр гэдэг хөтөлбөрийг бид нар ба баталлаа. Хуучин бол АШУИС-ийн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр тусдаа, Эрүүл мэндийн яамны хөгжлийн төв нь төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр тусдаа байсныг бид нар бол нэг болгож өгсөн. Мөн энэ жил бас эс резидент буюу

үндсэн мэргэжлээр элсэж байгаа эмч нарынхаа тоог бас нэлээд нэмэгдүүлж, төрлийг бас нэмэгдүүлэх чиглэл дээр ингээд ажиллаж байна аа?

Цаашидаа бид нарын хувьд хүний нөөц дээр байгаа гол асуудал юун дээр байна гэхээр сувилагчийн одоо бэлтгэх асуудал байгаад байдаг. Эрүүл мэндийн яам, Боловсролын яамтай хамтраад сайдын түвшинд бол хамтраад сувилагчийг яаж бэлтгэх вэ гэдэг дээр бид нар бас бодлого арга хэмжээ аваад явж байна.

Дипломын одоо боловсролоор эзэмших сувилагч нарын тоог нэмэгдүүлэх чиглэлээр, жишээлбэл Өвөрхангай аймаг дээр анагаахын шинжлэх ухааны Сувилахуйн сургуультай хамтраад бид нар орон нутагт нь сувилагчийг бэлтгэх энэ ажлыг энэ жил эхлүүлээ.

Тэгэхээр энэ бол цаашидаа бас нэлээд ийм загвар болох үйл ажиллагаа болно гэж харж байна. Мөн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв дээр бид нар бас яг энэ ажлын байран дээр нь туслах сувилагчийг дипломын сувилагчаар төгсгөх бас хөтөлбөрийг эхлүүлэхээр бид нар бас зориод ажиллаж байна. Тэгэхээр сувилагчийн асуудал дээр бол онцгойлон анхаарахгүй бол болохгүй байгаа нь бол харагдаж байгаа юм.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Энэ боловсон хүчний хангалтын асуудлыг бид нэлээн бодмоор болчихоод байгаа юм. Манайд сувилахуйн чиглэлийн улсуудыг заавал бакалавраар урт удаан хугацаагаар бэлдээд байх шаардлага байгаа юм уу? Социйн үеийн явж байсан тэр сургалтын систем нэг их хоцрогдоогүй

л болов уу гэж би боддог. Яг үнэнийг хэлэхэд. Дээр нь ерөөсөө гадагшаа гарч байгаа ажиллах хүчний чинь бас тодорхой хэсэг нь энэ сувилахуйн чиглэлийн улсыг чинь татаж авч явчхаад байгаа тийм үйл явц их тодорхой харагдаж байна шүү дээ. Тэгэхээр зэрэг бид энэ нөхцөл байдлаа харж, тэр хэдийгээр аль яаманд харьяалагдах нь хамаагүй захиалгаа өгч хүмүүсээ бэлтгэх хөтөлбөрийнхөө агууламжийг өөрсдөө боловсруулах тухай асуудал энэ Эрүүл мэндийн яамны гол асуудал байх ёстой.

Дамаан энэ хөдөөгийн эмнэлгүүдийг эмч, эмнэлгийн мэргэжилтнээр хангах асуудал бидний мөнхийн сэдэв байх ёстой. Энэ онцлогоо харгалзаж яаж тэр орон нутагт ажиллах эмч мэргэжилтнүүдийг бэлтгэх үү, яаж урамшуулах вэ гэдэг асуудал байгаад байгаа юм.

Г.Занданшатар: Үг хэллээ санал байна.

Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Үнэхээр Байнгын хороон дээр бид нар асуусан. Баярсайхан гишүүнийг ч гэсэн нийт эрүүл мэндийн тухай асуудал бас энэ тал руу чиглэгдэж байгаа болов уу гэж би бодож байна. Би Өрхийн эрүүл мэндийн төв болон сумын Эрүүл мэндийн төвүүдийн хүний нөөцийн асуудалд, тэнд үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эмнэлгийн ажилтнуудын маань үйлчилгээ үзүүлэх тэр чадвар, чадамж болоод тэр боломж бололцоо нь хэр байгаа юм бэ гэдэг асуултыг асууж байсан. Яг энэ чиглэлээр Өрхийн эрүүл мэндийн төв болоод сумын Өрхийн эрхүүл мэндийн төвүүд нь одоо нийтийн эрүүл мэнд рүү чиглэсэн бүлэг

иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, мөн хүн амын эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх энэ үүргийг хүлээсэн байдаг. Яг энэ үүргээ эдлэгдэх тэр боломжийг нь ер нь Өрхийн эрүүл мэндийн төв болон анхан шатны эмнэлгүүдэд сумын эмнэлгүүдэд ер нь хэр байна вэ гэдэг зүйлийг асуух гэсэн юм.

Яг энэ бүхэн нь өөрөөр хэлэх юм бол нөгөөдөх Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагддаг эрүүл мэндийн оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад ордоггүй. Өөрөөр хэлэх юм бол нэгэнт үүрэг хүлээсэн Өрхийн эрүүл мэндийн төв болон сумын эмнэлгүүд маань энэ үйлчилгээгээ үзүүлснээрээ нөгөө гүйцэтгэлээрээ санхүүжих тэр санхүүжилтэд нь одоо нөлөө үзүүлдэг үү гэдэг асуултыг нэгдүгээрт асууя аа?

Хоёрдугаарт нь би бас оношилгооны тал дээр илүүтэй их анхаараач ээ, ургийн гажиг төрөлт маш их байна гэдэг зүйлийг ихээр тавьж байгаа. Өөрөөр хэлэх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрсний дараа биш, ургийн явцад нь бид нар илрүүлэх ёстой гэдэг зүйлийг ярьсан. Эрүүл мэндийн сайд бас 4 ч оношилгооны төвийг бий болгож байгаа гэдэг дэгээр ярилаа. Сая гишүүний асуултад хариулахдаа нярайн скрининг үйлчилгээ нийтдээ 25216 эх үйлчлүүлсэн гэж байна. Бид юутай ч одоо энэ 4 төвөөрөө оношилгоогоо хийдэг болох нь. Тэгвэл бид нар шалтгааныг олох ёстой, яагаад ургийн гажигтай хүүхдүүд нэмэгдээд байна тийм ээ, яагаад ургийн гажиг нэмэгдээд байна. Агаар орчноос болоод байна уу, үнэхээр идэж болж байгаа зүйлээс болоод байна уу, энэ дээр судалгаа хэр хийгдэж байгаа вэ гэдэг асуултыг тавих гэсэн юм аа.

Нөгөөтээгүүр одоо Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль орж ирнэ ээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулж байгаа. Би Аюурсайхан сайд болон Энх-Амгалан сайдтай тус тусад нь уулзаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ асуудлыг яг энэ хуульд хэрхэн яаж тусгах юм гэдэг асуудлаар ярилцаж, санал солилцсон. Энх-Амгалан сайд ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн тогтолцооны өөрчлөлтийг хийе гэдэг зүйлийг ярьж байгаа. Сайд өөрөө тогтолцоог өөрчлөхийн тулд бас ажиллаж байна аа. Энэ дээр Энхболд сайдаа яг хамтарч чадаж байна уу? Би яагаад гэвэл энийг аль нэгэн яаманд хамааруулан үлдээмээргүй байна. Өөрөөр хэлэх юм бол эрүүл мэндийн үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ Эрүүл мэндийн яам нь хариуцаад, боловсролыг нь Боловсролын яам хариуцаад, халамж үйлчилгээг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж орхигдуулалгүйгээр энэ 3 яам хамтдаа тогтолцооны шинэчлэлийг хийж чадах аваас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн рүү чиглэсэн үйл ажиллагаагаа бид нар ба бүхэлд нь хийж чадах болов уу гэж би харж байгаа.

Энэ дээр бас таны саналыг сонсьё. Нэгэнт СЭМҮТ-ийн одоо удирдлагаас ирчихсэн байгаа учраас.

Г.Занданшатар: Энхболд сайд.

С.Энхболд: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

Би хамгийн сүүлийн асуултад хариулаад, өмнөхийг нь Буянтогтох дарга хариулчих байх.

Бид нар Энх-Амгалан сайд бид 2 бас уулзсан. Ялангуяа энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг бол ноднин бас 9 сард бид нар яг газар дээр нь очиж тэр сургалтын төв одоо ямар боловсрол олгож байгаа юм, одоо тусламж үйлчилгээ нь яаж явдаг талаар бас газар дээр нь танилцаж байсан. Энэ онд ч гэсэн бид нар бас хэд хэдэн газар дээр очиж нөхцөл байдалтай нь танилцсан. Тэгээд ерөнхийдөө Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Боловсрол, шинжлэх ухааны яамтайгаа бол хамтраад энэ дээр ялангуяа бид бүхэн бол юу гэж тохирч байгаа вэ гэхээр яг таны хэлж байгаа шиг цогцоор нь энийг нэг мөр шийдье ээ, тэгэхгүй бол одоо ингээд л бас яг таны хэлдэг шиг нэг нэг яаман дээрээ хэсэг хэсгээрээ тусламж үйлчилгээгээ авчхаад, одоо энэ дунд нь бас энэ чинь яг хэрэгжилт дээр тийм дорвитой үр дүн гарахгүй байгаа учраас бид бүхэн 2 сайд бол ямар ч байсан ярилцаад цогц нэг тогтолцоог нь бий болгож өгье өө гэдэг дээр бол санал нэгтэй байгаа. Тэгээд энэ ажлууд маань 2023 оноос л хийгдээд эхэлнэ гэдгээ бас танд хэлж байна.

Г.Занданишатар: 87. Гүйцээж хариулъя.

Б.Буянтогтох: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Буянтогтох.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүд яг одоо авч байгаа тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн чадамж хэр байна вэ гэж байна. Бид бол анхан шатны эрүүл мэндийн байгууллага бол манай системийнхээ хувьд бол хаалга барих тусламж үйлчилгээ үзүүлдэг. Түрүүн сайд дурдсан. Хамгийн одоо чухал хэсэг дээр ажиллаж байгаа. Яг энэ одоо

секторт ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг чадавхжуулах асуудал бол Эрүүл мэндийн яамны хувьд хамгийн чухал асуудлуудын нэг ээ. Бид ч бас энэ тал дээр бол байнга одоо орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудаар дамжуулж чадавхжуулах сургалтыг, богино хугацааны сургалтуудыг бол хийж явж байна. Жил болгон бол яг энэ чиглэлээр хийдэг.

Та тухайлж одоо оношийн хамааралтай бүлгээр санхүүжилт авахад энэ чадамж нь хэр байна гэхээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас Өрхийн эрүүл мэндийн төвүүд бол багцын 4 төрлийн тусламж үйлчилгээ авч байгаа. Энэ дээр бол харьцангуй гайгүй. Таных бол илүү тодруулж асуусан зүйл бол сумын Эрүүл мэндийн төвийнх болов уу гэж бодож байна. Сумын Эрүүл мэндийн төв дээр лавлагаа шатлалын оношны хамааралтай бүлгээс 4 чиглэлээр тусламж үйлчилгээ авч байгаа. Энэ нь бол бас энэ сумын Эрүүл мэндийн төвүүдийн хувьд бол санхүүжилтээ бас нэмэгдүүлэх ийм боломж гэж үзэж байгаа. Тэгэхээр 4 төрөл дээр жишээлбэл түргэн тусламж, яаралтай тусламж, хэвтэн эмчлүүлэх гэх зэрэг энэ тусламж үйлчилгээнүүд, дээр нь шүдний тусламж үйлчилгээ байгаа. Хэвтэн эмчлүүлэх болон Яаралтай түргэн тусламжийн хувьд бол өмнө нь хуучин ЭМД-ын санхүүжилтээр гүйцэтгэлээр аваад явж байсан. Энэ дээр бол чадамжийн асуудал харьцангуй гайгүй. Эрүүл мэндийн яамнаас бол барьж байгаа зүйл бол энэ яаж одоо 300 гаруй сумын Эрүүл мэндийн төвүүд дээр шүдний тусламж үйлчилгээ үзүүлэх асуудлыг чадавхжуулах асуудал хамгийн чухал болчихоод байгаа.

200 гаруй сумын Эрүүл мэндийн дээр бол яг энэ шүдний амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадамж хараахан бүрдээгүй байгаа. Тэгэхээр бид бол яг энэ чиглэлээр бол хүний нөөцийн болоод тоног төхөөрөмжийг одоо бэхжүүлэх чиглэлээр ойрын жилүүдэд бол ажиллана. Өнгөрсөн жилийн хувьд ч гэсэн бид нар бас нэлээдгүй олон сум дээр бас энэ тоног төхөөрөмжтэй холбоотой бэхжүүлэлтийг нь хийсэн. Хүний нөөц дээр ямар асуудал гардаг вэ гэхээр яг одоо шүдний эмчээр мэргэшсэн эмч нар шууд одоо сумын Эрүүл мэндийн төв дээр очиж ажиллах энэ бололцоо тэд нарын хүсэл сонирхол бол хараахан бол байхгүй байна.

Шүдний салбарын тусламж үйлчилгээ бол улсын хэмжээндээ аваад үзэхэд нэлээд дийлэнх хувь нь бол хувийн хэвшил дээр явдаг. Тэгэхээр шүдний эмчээр төгсөж байгаа эмч нар сум руу явах гэхээсээ илүү нөгөө төвлөрсөн газраа ажиллах төвлөрсөн газар дээрээ хувийн хэвшилд ажиллах сонирхол нь илүү түлхүү байгаа нь бас энэ бодлогыг цаашаа үр дүнтэй аваад явахад бас саад бэрхшээл болж байгаа.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулъя.

Б.Жаргалмаа: Буянтгогтох даргаа би түрүүн ингэж асуусан юм. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийгмийн эрүүл мэндийн ажилтан дутагдалтай байгаа. Өрхийн эрүүл мэндийн төвийн үзүүлэх үйл ажиллагаанд бүлэг хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох ийм заалт тусгагдсан байдаг. Тэд ийм үйлчилгээ үзүүлдэг. Энэ нь оношны хамааралтай бүлгийн жагсаалтад нь ордог уу, энэ хүмүүс ажил хийсэн болж, гүйцэтгэлд нь санхүү цалинд нь нэмдэг үү гэж асуусан юм. Сэтгэцийн эрүүл мэндийн

үндэсний төв утасны хамаарал, тоглоомын хамаарлын нөхцөл байдал хэр байна вэ? Бид үүн дээрээ урьдчилан сэргийлэх, нөгөө нийгмийн эрүүл мэндийн нийтийн эрүүл мэндэд чиглэсэн сургалт сурталчилгаагаа хийж чадаж байна уу? Яагаад ийм хүүхдүүд нэмэгдээд байна вэ? Гэдэг асуултыг асууя.

Нөгөөтээгүүр сургуульд хичээл орж байгаа эрүүл мэндийн хичээл нь яг энэ тал руу чиглэгдсэн хичээл сургалт нэмэгдэж чадсан уу? Энэ өөрөө цаг үеийн нөхцөл байдлаар нэмэгдсэн ийм хамаарал учраас нэмэгдэж чадсан уу? Гэдэг асуултыг асууя.

Г.Занданшатар: 87.

Б.Буянтгогтох: Нэмэлтээр хариулъя Буянтгогтох. Яг оношны хамааралтай бүлэг дээр бол энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ бол өртөгжөөгүй байгаа. Гишүүний хэлсэн бол үнэн. Тэгэхээр бид нар бол энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг аль талын өртөг рүү нь шингээж өгсөн гэхээр нэг иргэнээр тооцсон санхүүжилтээр нь энийг нь оруулж өгсөн байдаг. Ерөнхийдөө бол нэг анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд олгож байгаа нь нэг иргэнээр санхүүжүүлж байгаа санхүүжилтийн цаад агуулга нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бэхжүүлэхэд чиглэгдсэн ийм одоо санхүүжилтийн хөшүүрэг байдаг. Тусламж үйлчилгээ нь бол яг тэр тусламж үйлчилгээнийхээ багцаараа тохиолдолд суурилсан аргаараа санхүүжилт нь авдаг ийм загвараар явдаг юм.

Г.Занданшатар: 88.

В.Баярмаа: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв Баярмаа. Тэгэхээр жилдээ бол яг СЭМҮТ-д бол 300 орчим хүүхэд, өсвөр насны хүүхдүүд одоо амбулаториор үзэгдээд явж байна. Энэний бол 70-80 хувь нь бол дэлгэцийн хамааралтай ийм хүүхдүүд бол хандаж байгаа. Гол одоо хандаж байгаа хүүхдүүд маань бол дандаа өсвөр насны эрэгтэй хүүхдүүд илүү байгаа. Тийм учраас энэ рүү чиглэсэн зорилтот арга хэмжээ болгож гол эхэлж байгаа нас нь бол 10-12 нас буюу эрүүл мэндийн хичээлийн бага ангийн боловсрол олгох дээр бол тусгайлан цахим хэрэглээ гээд эрүүл мэндийн хичээлийн 6 агуулгын 4 дүгээр агуулга нь бол хорт зуриил гэсэн бүлэг байгаа. Тэрний одоо яг 4-6 дугаар ангийнх дээр нь бол яг энэ дэлгэцийн хамаарлын агуулга бол орсон байгаа.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн алга байна. Булааны Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ сайдын мэдээлэлтэй холбоотой бас хэд хэдэн асуулт асууя.

Энэ хөдөө аймгуудаас хотод ирж байгаа өвчтөнүүд энэ хавдартай өвчтөнүүд нэлээн ширвэгдэж байна. Эмнэлгүүд одоо 2, 3 сарын очертой болчихсон. Энэ талаар одоо та ямар арга хэмжээ авах гэж байна вэ? Ер нь уртасгасан цагаар ажиллуулах боломж байна уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ хөдөөд баригдаж байгаа эмнэлгүүдийн санхүүжилтээр би одоо 3 дахь удаа бичиг явуулж байна. Ногоон нуур сумын Ховд багийн эмнэлгийн нэг 50 сая төгрөгийн санхүүжилт суусан.

Нөгөө юу нэмэлт ноднин бүр төсөвт тусгасан. Тэрийгээ одоо одоог хүртэл авч чадахгүй байна гээд надад өчигдөр бас дахиад уржигдар бичиг явуулсан. Энийг Эрүүл мэндийн яам хөгжлийн төвтэй гэрээ хийдэг юм байна, сонгодог юм уу? Би сайн ойлгохгүй байна. Энэ талаар нэг тодорхой хариулт өгөөч ээ. Яагаад ойлгохгүй байна?

Хоёрдугаарт, одоо энэ эмийн үнийн талаар одоо энэ хотын клиникийн эмнэлгүүд дээр чинь эм нийлүүлэх эм ханган нийлүүлэх компаниуд эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг он гараад нэмнэ шүү гээд урьдчилаад одоо яачихсан байна, энэ талаар төсөвт яаж тусгав. Эмийн үнийг буулгах гээд байдаг. Гэтэл одоо ингээд нэмэгдсэн байдалтай байна. Энэ талаар асууя.

Дараа нь 2023 оны төсөв дээр эхийн эндэгдлийн харьцаа 2021 онд 20.4 байсан байна. Одоо ингээд 2023 онд 20.6 болгосон дүнтэй өгчихсөн байх юм. Дандаа өссөн, нялхсын эндэгдэл мянган амьд төрөлтөд 11.6 байсан 11.8 болгоод 2023 онд.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 12.3 байна. 13.5 болох ийм өссөн дүнтэй. Энэ талаар тодорхой асууя. Буруу яачхав уу, аль эсвэл одоо энэ өссөн дүнгээр яагаад дуусах гэж байгаа юм бол энэ талаар асууя даа? Эмч нарын цалингийн хувьд үнэхээр сая гишүүд ярьж байна. Үнэхээр одоо нэмэгдэхгүй байна аа энэ талаар та бас анхаарна биз дээ? Би бас урьд нь бас хэлж байсан. Энэ талаар анхаарахгүй бол үнэхээр одоо энэ эмч нар, сувилагч нар ажлаас их гарч байна, энийг одоо судалж үзсэн үү? Хотын эмнэлгүүд чинь дандаа ажилдаа эмч сувилагч авна гэж зар тавиад байна.

Энэ талаар хийсэн судалгаа байна уу? Эмнэлэгүүдээр яваад.

Г.Занданшатар: 81. Энхболд сайд.

С.Энхболд: Бейсен гишүүний асуултад хариулъя.

Эхний ээлжид хөдөө орон нутгаас, ялангуяа энэ хавдрын тусламж үйлчилгээг чирэгдэл учирч байна гэж. Энэ дээр бас нэлээн бид бүхэн бас томоохон бодлогын ажлууд хийгдсэн. Ганцхан Халдварт өвчин судлалын үндэсний төв дээр хавдрын тусламж үйлчилгээ үзүүлэх биш, төр болон хувийн хэвшлийн лавлагаа шатлалын эмнэлгүүдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг болоод эхэлсэн байгаа. 1, 2, 3 дээрээс нь бас хэд хэдэн хувийн томоохон эмнэлгүүд хавдрын тусламж үйлчилгээ үзүүлдэг болсон. Энэ маань өөрөө аль болох л иргэдэд энэ тусламж авч, ялангуяа хавдрын тусламж үйлчилгээ авах гэж байгаа иргэдэд илүү хүлээгдэлгүй чирэгдэлгүй, одоо тусламж үйлчилгээ хүртээмжтэй байлгах үүднээс ийм бодлогын төвлөрч сааруулах ажлуудыг бол хийсэн.

Дээрээс нь бас орон нутгуудыг, бас бид нар үе шаттай чадавхжуулж, ялангуяа орон нутагт бас энэ тусламж үйлчилгээ үзүүлдэг болгох чиглэлээр ажил хийж, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг бас эхнээс нь гардуулаад явж байгаа. Одоо жишээ нь гэхэд Хөвсгөл аймгаас бол хавдрын оноштой өвчтөн бараг Улаанбаатар руу ирэх эрхгүй болсон байгаа. Энэ мэтчилэн бол бид нар төвлөрөл сааруулах ажлуудыг бол хийж байгаа. Жишээ нь бас энэ бөөр шээсний зам урлогийн мэс заслын тусламж үйлчилгээг бас бид нар 15 аймагт

хийдэг болсон. Энэ маань өөрөө ганцхан улсын төв эмнэлэг дээр Нэгдүгээр төв эмнэлэг дээр төвлөрдөг байсныг бол задалж орон нутагт хийгддэг болсон.

Хоёр дахь асуулт эмийн үнийн асуудал ярьж байна. Эмийн үнийн асуудлыг бол бас яам ганцаараа зохицуулж дийлэхгүй байна. Яагаад гэхээр үнэхээр одоо зах зээл дээр улс орны эдийн засгийн хямрал, дээрээс нь энэ Орос, Украйны нөхцөл байдалтай холбоотой бас тээвэр ложистикийн асуудлууд. Мөн түүхий эдийн бүтээгдэхүүний асуудлууд бас нэлээн хомсдол үүсэж, бараа товарын тээвэрлэлтийн үнэ нэмэгдсэнтэй холбоотой, бас эндээ шууд дам нөлөөлж байна.

Энэ бол яалт ч үгүй эмэн дээр бол шууд үнэ өсөхөд нөлөөлж байгаа. Бид бүхэн бол энэ ЭМДҮЗ-ийн 01 тогтоол дээр бас энэхүү эрсдэлийг тооцож 2022 орныхоо юун дээр бол 7 хувийн инфляцыг бол шингээж оруулж оношийг баталсан. Мөн дахин бас яг энэ юун дээр 01 тогтоол дээрээ, бас бид бүхэн бас энэ 705 дээр бас ажлын хэсэг гараад ажиллаж байна. Энэ 1 сарын 1-нээс эхлэн, бас энэ 01 тогтоолыг бас тодорхой түвшинд бол өөрчлөлтүүдийг оруулж тохируулгуудыг бол хийнэ. Энэ дээр бас энэ бол ялангуяа энэ инфляцынхаа үнийн өсөлттэй холбоотой тохируулгуудыг хийж байгаа гэсэн үг.

Эхийн эндэгдлийн асуудлыг Нарангэрэл дарга Нарангэрэл дарга хариулъя.

С.Одонтуяа: Одоо Дамдинням гишүүн асуулт асууя. Бейсен гишүүн тодруулъя.

83 дугаар микрофон нэмж хариулъя.

Т.Мөнхтуул: Бейсен гишүүний асуултад хариулъя.

Санхүү, эдийн Засгийн газрын дарга Мөнхтуул байна. Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сумын барилгын ажлын явцыг бол асуулаа. Энд бол Дайчин хөлөг компани бол ажлыг бол гүйцэтгэж байгаа. Тэгээд нэмэлт ажлын асуудлыг бол бид нар шийдвэрийг нь гаргуулахаар Барилгын хөгжлийн төв дээр одоо хянагдаад явж байна. Нийт одоо 340 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд бол 299 саяар бол гэрээ байгуулсан. Нэмэлт ажлын төсвийг бол ярьж байгаа. Барилга бол ашиглалтад орчихсон. Тэгээд Барилгын хөгжлийн төвийн шийдвэр одоо ирэхээр бид нар энийг нэмэлт төсвөөр шийдвэрлэхээр ажиллаж байна.

С.Одонтуяа: Эхийн эндэгдлийн талаар хариулъя.

85 дугаар микрофон. Эх нялхсын эндэгдлийн талаар.

В.Баярмаа: Эхийн эндэгдлийн түвшинг суурь оны түвшингээ 2020 онд бол 23, 2021 онд 21.4 байсан. 2022 онд 20.6, 2023 онд 19.8 гэдгээр тавьсан байна. Өнгөрсөн онд бол бид бүхэн бол зорилтот түвшиндээ бол хүрч чадаагүй. Яагаад гэхээр ковидын улмаас эхийн эндэгдлийн түвшин 90.6 дээр хүрсэн байгаа. Гэхдээ 2022 болон 2023 онд бол зорилтот түвшиндээ хүрнэ гэсэн байдалтай төлөвлөлттэй ажиллаж байгаа.

С.Одонтуяа: Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Энэ бид нарт өгсөн 2023 оны төсвийн юун дээр Эрүүл мэндийн сайдын эмнэлгийн тусламж үйлчилгээ гэдэг дээр чинь наана чинь буруу орчихсон байна шүү. Энийгээ засахгүй бол одоо 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл мянган амьд төрөлтөд 12.3 байсан байвал 2021 онд, 2023 онд 13.5 болгоод ингээд яачихсан байна. Тэгээд нөгөө талаар бас тийм өссөн дүнгээр тавьчихаар чинь эд нар бас буруу ойлголт тавина шүү дээ. Тэрийгээ засаад янзлахгүй бол болохгүй юм шиг байна.

С.Одонтуяа: Одоо Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууна.

Г.Дамдинням: Би сая тойргоороо яваад ард иргэдтэй уулзсан юм. Тэгээд энэ манай ахмадуудын нэг асуугаад өгөөч гэсэн 2, 3 асуулт байна. Би танд бас нэрээр нь хэлчихье. Дархан уул аймгийн Дархан сумын 4 дүгээр багийн иргэн Түвшинтөгс, 12 дугаар багийн иргэн Болор хаан, 11 дүгээр багийн иргэн Эрдэнэцэцэг, 15 дугаар багийн иргэн Амгалан, Өргөө багийн иргэн Батаа, 15 дугаар эргийн багийн ахмад настан Ядамжав, 11 дүгээр багийн ахмад настан Эрдэнэцэцэг гээд. Энэ хөгшичүүд маань бол юу асуугаад байгаа вэ гэхээр жор бичих эрхийг өрхийн эмнэлэг бичиж байгаа. Тэр жороороо авч болно эрүүл мэндээр гээд байгаа боловч үзүүлээд очихоор зэрэг заавал нарийн мэргэжлийн эмчийн жор бичиж ир гээд явуулаад байна. Энэ асуудлыг нэг нэг талд нь гаргаж шийдэж өгөөч гэдэг нэг ийм асуулт байгаа юм. Энэ ямар учиртай юм яваад байгаа юм бэ гэдгийг бас нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт, эмийн жор дээр эмч нь 20 микрограммтай нэг эм бичихдэг юм байна. Тэгээд

даатгалтай аптек дээр очоод авахаар зэрэг нөгөө аптек нь манайд 20 миллиграммтай байхгүй, 15 миллиграммтай байна. Тийм болохоор танд өгөхгүй ээ гээд өгдөггүй юм байна. Тэгээд энэ асуудлыг бас ер нь юу болоод байдаг юм, яаж шийдэх ёстой юм гэж асуулгаж байгаа юм.

Гуравдугаарт бол манай ахмадууд нэг 520 мянган төгрөгийн тэтгэвэртэй, хамгийн бага нь. Тэгээд энэ эмийн үнийн өсөлт бол одоо тэнгэрт гарчихжээ. Ер нь бол дийлэнх нь л хөөрхий минь одоо зүрх судас даралтын эм ууцгааж байгаа. Сар хэрэглэдэг эмээ авахад 280000 төгрөгөө зарцуулдаг юм байна, одоо. Энэ үнийн өсөлтийн үед. Энэ нь тэгээд энэ 300 гараад явчихдаг юм байна, зөвхөн даралт зүрхнийх нь эмнэ шүү. Тэгээд цаана нь өөр олон эм хэрэглэнэ. Тэгээд ер нь бол тэгээд хоолоо идэх үү, эмээ уух уу, хувцсаа өмсөх үү л болж хувирч байгаа юм байна аа. Тэгээд энэ эмийн үнийн өсөлт дээр одоо энэ даатгалын хөнгөлөлтийг нь хуучин байсан 75 хувь энэ тэрийгээ, 70 гаруй хувь энэ тэрээ өсгөж болдоггүй юм уу? Энийг чинь одоо 30 хувь болгоод бууруулчихсан байна гээд байна аа. Тэгээд энэ даатгал дээр та нар ер нь ямар зохион байгуулалт хийж байгаа юм бэ гэдэг асуулт байна.

Дөрөвдүгээрт, би саяхан Английн элчин сайдтай уулзсан. Английн элчин сайдтай уулзахад Английн элчин сайд танай энэ ЭМЯ өрсөлдөөнийг оруулж ирж, энэ эмийн үнийн өсөлтийг бууруулах, хоёрдугаарт чанарыг сайжруулах чиглэлд ерөөсөө ажиллахгүй байна. Манай Англи улсын эм ханган нийлүүлэх компаниуд орж ирэх гэхээр бараг л орж ирэх боломжгүй дүрэм журам тулгаад байна гээд байна аа. Энэ асуудлыг ер нь та нар чинь яаж

шийдэж байгаа юм бэ? Хамаагүй хямд, хамаагүй чанартай эм орж ирэх нөхцөл байгаа юм байна лээ шүү дээ, уг нь бол.

С.Одонтуяа: Эрүүл мэндийн сайд Энхболд хариулъя.

С.Энхболд: Дамдинням гишүүний асуултад хариулъя.

Сая 9 сарын ЭМД-ын Үндэсний зөвлөлөөр энэ тогтоолыг ялангуяа эмийн хөнгөлөлтийн тогтоолыг бол бид нар өөрчилсөн. Энэ дээр зарим нэр төрлийн эмийг 70 байсныг 50, 30ч руу буулгасан. Энэ дээр бол мэдээж, манай бас нэлээн хэсэг ахмадууд маань бас нэлээн уцаарласан. Энэ дээр хамгийн гол нь яагаад буулгасан бэ гэхээр бид нар Новартс компаниар 16 нэр төрлийн 24 эмийг оруулж ирсэн. Энэ маань өөрөө 1 долларын үнэтэй. Бас чанартай ийм эмийг бид нар 6 улсын хатуу зохицуулалттай оронд хэрэглэдэг эмийг нэг доллароор Новартс хөтөлбөрөөр оруулж ирж байгаа. Энэ маань одоо өнөөдрийн байдлаар бол бүх эмийн сангуудаар тараагдчихсан, борлуулагдаад эхэлчихсэн байгаа. Энэ дээр одоо яах вэ жоохон цаг хугацааны хувьд жоохон зөрүү гарч, нөгөө эм маань бүртгэх явцад цаг хугацаа алдсан учраас энэ чинь бол жоохон тийм бухимдал юу үүссэн нь буцаад ингээд нөхөгдөөд ирэхээр аяндаа иргэдээс одоо зарцуулж байгаа, ялангуяа манай улс шиг одоо энэ эрсдэлтэй бүлгээ хөнгөлөлттэй эмээр яадаг улс маш цөөхөн улс байдаг. Ялангуяа төр нь бас энэ чээ бас тодорхой дэмжлэг үзүүлж, даатгалын сан дээр жил болгон бид нар энэ хөнгөлөлттэй эмийн зардлыг өсгөж тавьж байгаа юм. Ноднин бол 2022 онд бол бид нар 67 тэрбум байсан бол энэ жил бид нар 90 болгож нэмсэн. Энэ маань аль болох л иргэд рүүгээ чиглэсэн

хөнгөлөлттэй эмийг төрөөс дэмжлэг үзүүлэх зорилготой. Мэдээж амьдралын чанарыг бас уртасгах зорилготойгоор одоо яг таны хэлдгээр зүрх судасны өвчин даралтын эмүүдийг бол нэлээн түлхүү авдаг.

Тийм учраас бид нар бас энэ эм дээр нь Новартс компаниас жишээ нь одоо Амлодипин гээд эмийг өмнө нь бол 33000 төгрөгөөр борлуулагддаг байсан нэг курс 1 сарынх нь хэрэглээ. Тэрний 27000 нь бол даатгалаас хөнгөлөгддөг, үлдсэн нь бол хувь хүнээс гардаг байсан. Одоо энэ Амлодипин гэдэг юмыг Новартс хөтөлбөрөөр оруулж ирэхэд энэ маань өөрөө 9160 төгрөг. Яг борлуулах үнэ нь. Тэгэхээр даатгалаас 8000-ыг хөнгөлж өгнө. Үлдсэнийг нь хувь хүн өөрөө төлнө. Ингээд ирэхлээр нь энэ бол бодит хэмнэлт болно дээрээс нь энэ эмийн чанарт нөлөөлнө өө гэсэн үг. Тэгээд энэ бол ингээд зохицуулалт хийгээд явж байгаа гэдгийг хэлэх гэсэн юм. Ялангуяа бид нар одоо энэ гадна дотны бас үйлдвэрүүдээ бас дэмжиж байгаа. GMP үйлдвэр хангах эмийн компаниудыг бол бид нар дэмжлэг үзүүлээд явж байна.

Дээрээс нь манай улсад үйлдвэрлэгдсэн экспортод гаргахад бол бид нар дэмжлэг үзүүлж байгаа. Сая бол тэр Новартс гээд компанийг бол Засгийн газар хооронд бол гэрээ байгуулж оруулж ирсэн. Энэ маань өөрөө бас бодлого дээр ингэж тодорхой хэмжээгээр төр оролцож байгаа гэсэн үг. Тэгэхдээ цаашид мэдээж төр, хувийн хэвшилтэйгээ хамтраад явна. Мэдээж гаднын хөрөнгө оруулалттай үйлдвэр барихад бол манай үүд хаалга бол нээлттэй байгаа. Бид нар ямар нэгэн тийм шахалт дарамт бол үзүүлдэггүй.

С.Одонтуяа: Хэн нэмж хариулах вэ?

С.Энхболд: Ийм байгаа юм. Энэ дээр бас бид нар EBCD гэдэг жор бичигтэй ийм 4 түвшнийг гаргасан. Ялангуяа манайх шиг бас энэ антибиотикийн эмийн хэрэглээний ийм зохисгүй хэрэглээтэй улсад бол энэ заавал байх ёстой тогтолцоо. Мэдээж одоо цус шингэлдэг ямар нэгэн эмчийн уухад заавал тодорхой хэмжээний хэсэг хугацааны дараа тэр хүнд нь шинжилгээ хийж үзэх ёстой. Нарийн мэргэжлийн эмчид үзүүлж байж одоо эмнийхээ тунг нэмэх үү, багасгах уу гээд энэ нь тэгж явах ёстой зарчим байгаа учраас энэ дээр энэ зохицуулалт хийсэн. Энэ дээр яах вэ иргэд маань бас нэлээн уурлаад байх шиг байна. Тэгэхдээ бол заавал хийх ёстой.

Тийм, мэдээж одоо тэр хүн зүрхний, ялангуяа тэр цус шингэлдэг эмийг өрхийн эмч байнга шууд автоматаар бичээд байж болохгүй. Тэгэхээр заавал нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээг харж байж цааш үргэлжлүүлж хэрэглэх үү, үгүй юу гэдгийг бас мэдээж яах ёстой, тохируулга хийх ёстой. Тийм учраас эндээ бид нар бас энэ тохируулгын жор бичилтийн юуг бол 4 түвшинд ангилж өгсөн юм байгаа юм.

С.Одонтуяа: 87 нэмж хариулъя.

Б.Буянтогтох: Дамдинням гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

ЭМЯ, Буянтогтох. Бид нар Английн парламентын гишүүдтэй ТНБД-ын хүрээнд бид нар бас уулзсан. Английн Их Британийн чанартай эмийг Монгол Улсад оруулж ирэх бололцоо хэр байна гэдэг талаас. Монгол талаас бүрдүүлэх бичиг

баримт дээр хөнгөлөлт хугацаа хожих энэ тал дээрээ бид нар харилцан ярилцсан байгаа. Цаашидаа бид нар яг энэ яг Новартс шиг чанартай эмийг хямд үнээр Монголд оруулж ирэх тал дээр Английн парламентын тэр төлөөлөл яг одоо ханган нийлүүлэх байгууллагатайгаа бид нарыг шууд холбож өгөхөөр болсон. Энэ ажил цаашиаа үргэлжилнэ гэж бодож байна. Сайдын өгсөн мэдээлэл дээр би нэг тоо баримт хэлье. Манайх бол тэр багийн эмчийн түвшинд, сумын эмчийн түвшинд, аймгийн түвшинд, төрөлжсөн мэргэжлийн түвшинд ингэж 590 эмийг бол ялгаатай байдлаар олгож байгаа. Иргэдийн зүгээс ямар асуудал гаргаж байна гэхээр ялангуяа зүрх судасны, цус шингэлэх, заавал нарийн мэргэжлийн эмчийн хяналтад уух ёстой эмийг багийн эмч сумын эмч, өрхийн эмчээрээ дамжуулж авах ийм хүсэлт байгаад байдаг. Гэхдээ тэр эмийн үйлчлэлийг тэр эмийн хүндрэлийг хянахын тулд зайлшгүй эмчийн үзлэгээр орж шинжилгээгээр тэрийг нотлох ийм хэрэгцээ гардаг учраас тухайлсан цөөн тооны эмүүд дээр бид нар энэ хязгаарлалтыг бол энэ удаагийн одоо 12 дугаар тогтоолоор бид нар бас шийдэж өгсөн. Энэ бид нар анхан шат болон лавлагаа шатныхаа эмч нарынхаа рецепт бичих буюу жор бичих энэ уялдаа холбоог нь сайжруулчихвал энэ аажимдаа бол зохицоод хэвшээд явчих зүйл гэж ойлгож байгаа. Гэхдээ сайдын хэлснээр энэ бол гарцаагүй хийх ёстой ийм зохицуулалт байсан гэдгийг бүр зориуд хэлмээр байна.

С.Одонтуяа: 85 нэмж хариулъя.

В.Баярмаа: Гишүүний асуултад хариулъя.

Ер нь бол эмчийн рецепт гэдэг нь бол тодорхой эмийг олон улсын нэршилээр нь, тэгээд тунг нь тодорхой зааж өгсөн хэдэн ширхгийг нь тавьсан юм нь рецепт гээд байгаа жор гээд байгаа. Тухайн жорын дагуу эм зүйч бол яг л тэр жорын дагуу л олгох ёстой. Тэгэхээр эмийн сан дээр энэ 20 граммтай, 20 милограммтай эмийн жорыг барьж очоод 15-ыг бол авч болохгүй. Тэгэхээр тухайн эмийн санчийн бол зөв байх нь. Харин эмч нар бол тухайн хүндээ таарсан тунгаа л бичиж өгч байгаа энэ болохоор 20-ын жорыг барьж очоод 15 миллиграммтай эмийг авч болохгүй ээ, тэр бол болохгүй байгаа юм.

Саяын бас тэр эмийг ялгаатай байдлаар бичээд байна аа? Жор яахад тэгээд заавал нарийн мэргэжлийн эмч дээр очих шаардлага байна гэдэг нь бодлогын түвшинд энэ эмийн зохисгүй хэрэглээ, эмээс гарч болох гэж нөлөөг бууруулах бодлого энд бол явж байгаа. Гэтэл иргэдээс ирж байгаа энэ бас хүлээгдэл чирэгдэл, энэ зохицуулалтын байдал алдагдалтай байна гэдгээс шалтгаалаад одоогоор бол энэ журам үйлчлэхгүйгээр бүх шатны эмч нар бол энийгээ бичиж байгаа. Тэгэхээр иргэдээс энэ чирэгдэл бол одоогоор байхгүй байгаа. Гэхдээ бодлогын хувьд бол бид нар энийг ямар нэгэн байдлаар хэвшүүлэх, мөрдүүлэх ёстой байгаа гэдгийг хэлье.

Баярлалаа.

С.Одонтуяа: Дамдинням гишүүн тодруулъя.

Г.Дамдинням: Энэ дээр би асуугаад байгаа юм энэ байхгүй юу? Ингээд нөгөө би та нарыг ойлгож байна л даа. Мэдээж би түрүүн асуусан шүү дээ, 20 граммаар ингээд жор бичээд өгчих юм ахмад настай

хүнд. Тэгэнгүүт тэрийг нь очоод даатгалаас авах гэхээр манай даатгалын эмийн жагсаалтад 20 граммтай нь байхгүй, 15 граммтай нь байна тийм болохоор та даатгалгүй авна гэдэг юм яриад байна л гэдгийг хэлээд байгаа юм. Түүнээс биш эмч нь одоо зөв бичээд аптект өгөхгүй байгаа нь зөв болоод байгаа тухай ерөөсөө асуулт биш байхгүй юу? Даатгалд яагаад хамрагдахгүй юм бичиж өгөөд байгаа юм бэ гэдэг л асуулт байна.

Хоёрдугаарт, ЭМЯ маань цаашид бол энэ Европын эмийн агентлаг мөн бас Америкийн эмийн агентлаг гээд энэ томоохон өндөр хөгжилтэй орнуудын эмийн агентлагуудын эмүүдийг дотооддоо шууд оруулдаг байх зохицуулалтыг хийх чиглэлд ажиллаач ээ. Тэгэхгүй бол бид нар бас энэ хүмүүст хүнд суртлыг хэтэрхий их үзүүлээд байгаа шүү гэдгийг хэлэх хэрэгтэй. Тэгээд саяын тэр граммын зөрүүг дахиад нэг хариулаад өг.

С.Одонтуяа: 85 нэмж хариулъя. Яг тодорхой асуусан асуултад нь л хариулчих.

В.Баярмаа: Ойлголоо. Энэ хөнгөлөлттэй эмийн жагсаалтууд яг энэ бас эмийн нэр тунгаараа заачихсан байгаа эмүүдийг л хөнгөлж байгаа учраас нэг кэйси байгаа гэж ойлголоо гишүүн ээ. Тэр хүнд бол яалт ч үгүй тийм асуудал учирсан байна. Харин энэ хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг гаргахдаа зонхилон хэрэглэгдээд байгаа эмийг мөн одоо яг тунг нь яг адилхан олон хүнд хэрэглэгдээд байгаа тунтай нь хамт оруулдаг учраас магадгүй зарим иргэдийн 20 биш 15-ыг хүсээд байгаа нь тухайн жагсаалтад байхгүй учраас хөнгөлөлттэйгөөр авах боломж гарахгүй байсан тохиолдол

цөөн хувьд бол байгаа байх гэж бодож байна.

С.Одонтуяа: Одоо Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууна.

В.Баярмаа: Бүгдийг нь одоо гишүүнээ оруулах боломж байхгүй байхгүй юу. Одоо бүх эмийг тэр байгаа тунгаар нь.

Б.Баттөмөр: Энэ хүн одоо хэвийн ажиллаж амьдрах эхний хамгийн эхний тавих шаардлага бол эм л байх ёстой. Бид нар нэг хөрөнгө оруулалтыг эрэмбэлнэ гэж яриад байдаг шүү дээ. Тэгээд би бол бодохдоо хамгийн түрүүн өнөөдөр эрүүл мэндийн салбарт Монгол Улс энэ хөрөнгө оруулалтыг маш сайн тавьж өгөх ёстой. Гаднын зээл тусламжийг энд хамруулах ёстой гэж ингэж боддог. Сая одоо 1 цагийн өмнө Монгол Улсын 2023 оны төсөв батлагдлаа. Эрүүл мэндийн салбар Монгол Улсын төсөвт 4.8 тэрбум төгрөг оруулдаг юм байна орлого. Буцаад авч байгаа 1 их наяд 279 тэрбум төгрөг авдаг. Энэний 1.1 их наяд нь бол урсгал зардал, 172 тэрбум төгрөг нь хөрөнгийн зардал байдаг юм байна. Ингээд үзэхээр энд өгч байгаа санхүүжилт бол харьцангуй их бага байна гэсэн нэг ийм юм байгаа юм. Энийг ингээд цаашидаа бид анхаарна биз. Цаг бага байгаа учраас шууд шууд асуултаа асуугаад явчихъя. Танайд нэг цахим хөтөлбөр гээд нэг хөтөлбөр 2016 оноос хойш эхтэй дунд нь зогсоод л бариад л энэ чинь одоо 14 бараг 16 жил явчих вуу. Сая 9 сард одоо хаалтаа хийсэн гэсэн энэ хөтөлбөр маань одоо ямархуу түвшинд байж байна аа. Ямархуу юм шийдэв гэсэн ийм нэг дэх асуудал.

Хоёр дахь асуудал нь Монгол Улсаас гадаадад одоо явж эмчлүүлж байгаа хэчнээн хүн байна аа? Ямар

хэмжээний мөнгө гарч байгаа бол? Та нарт тооцоо байна уу?

Гурав дахь асуулт бол юу вэ гэхээр гадаадад яваад байгаа, энэ ялангуяа хорт хавдартай холбоотой энийг одоо энэ Монголд тусалдаг Солонгос, Япон гээд орнуудтай тэр мэргэжлийн багуудыг нь энд авч ирүүлээд тэр Хөгжлийн банкн дээр бол мэргэжлийн баг ирж ажилласан шүү дээ. Тэрэнтэй адилхан ийм хэлбэрээр та нар одоо бодож санаж байгаа, тооцож байгаа юмнууд бол байна уу гэсэн ийм юм байна. Лабораторийн хөгжил бол үнэхээр их чухал ач холбогдолтой.

Монголд энэ лаборатори ер нь ямархуу хөгжилтэй байна гэсэн ийм асуулт байна.

Дараагийн асуудал энэ эд, эс, эрхтэн шилжүүлэх донороос одоо эрхтэн шилжүүлэх гээд энэ багуудын ажил ер нь ямархуу байна?

Энийг дэмжих чиглэл дээр ямархуу ажлууд хийгдэж байна аа? Гэсэн асуултууд байна.

Яах вэ, нийгмийн эрүүл мэндтэй холбоотой асуудлуудыг манайхан асуучихлаа. Би бол зүгээр энэ эрүүл мэндийн салбартай холбоотой энэ таны ажилтай холбоотой л хэдэн асуулт байна.

Энэ цус ойртолт Монголд их нэмэгдэж байгаа юм. Энэ чиглэлд та нарт ямар судалгаа байна? Юу хийх гэж байна? Тэгээд эх нялхсын энд эндэгдлийг бууруулах төрөлхийн хөгжлийн гажгийг эрт илрүүлэх чиглэлд энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд орчихсон асуудал шүү. Энэ чиглэлд та нар юу хийж байна аа? Энэ ЭМД-ын тогтолцоог

улам боловсронгуй болгох чиглэлээр юу хийж болох вэ? Ямар боломжууд байна аа? Энэ хамгийн сүүлчийн асуулт бол юу вэ гэхээр энэ Монголд бол дэлхийд ховор эмийн чанарын ургамлууд ургадаг. Энэ бол одоо цаашидаа Монгол Улсын экспортыг нэмэгдүүлэх том боломж. Экспортод бас гаргадаг л юм байна лээ. Тэгээд энэ чиглэлд ямар судалгаанууд байна? Юу хийж болмоор байна? Цаашидын чиг хандлага одоо юу байна? Энэ чиглэлд одоо ямар бодлогууд байна? Энийг асууя.

С.Одонтуяа: Эрүүл мэндийн сайд Энхболд хариулъя.

С.Энхболд: Тэгээд би Баттөмөр гишүүний цахим төсөл, ЭМД-ын тогтолцооны талаар хариулъя. Манайхан бусдыг нь хариулах байх.

Энэ цахим төсөлтэй холбоотой бас маш олон асуудлууд хэвлэл мэдээллээр явж байгаа. Энэ дээр хамгийн гол нь 2016 оноос эхэлсэн энэ Дэлхийн банкны санхүүжилтээр санхүүжиж байгаа энэ төсөл маань 2016 оны 6 сарын 2-ноос эхэлсэн байгаа юм. Энэ маань өөрөө хэрэгжих гэж явж бараг 4 жилийг алдсан. Яг албан ёсоор бол 2021 оны 9 сарын 27-ны өдөр барьцаа төлбөр чөлөөлөгдөж байж энэ маань яг эхэлсэн байгаа юм. ЭМЯ-тай хийсэн гэрээ бол тийм зохицуулалттай. Энэнээс өмнө бол ер нь дандаа тодорхой шалтгааны улмаас энэ маань гацчихсан. Би бас энэ танд хүснэгтийг одоо ингээд өгчихье. Энэ төслийг бол бид нар яах вэ Дэлхийн банк бол одоогийн байдлаар санхүүжилтийг зогсоосон. Тэгэхдээ энэ төсөл бол явж байгаа. Эрүүл мэндийн яамнаас хийсэн гэрээгээр бол 2023 оны 4 сард дуусахаар байгаа.

Тийм учраас энэ гүйцэтгэгч компани маань ажлаа хийгээд явж

байгаа гэсэн үг. Ямар ч гэсэн салбарын санхүүжилт бол хийгддэгээрээ хийгдээд явж байгаа.

Хоёр дахь асуулт ЭМД-ын тогтолцоо манай улсын хувьд бид бүхэн одоо 2020 оны 8 сард Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой эрүүл мэндийн салбар гүйцэтгэлийн санхүүжилт буюу нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэн. Энэ одоо хэрэгжээд жил 7 сарын хугацаа өнгөрч байна. Үүнд бас 1 жил орчим хугацаанд бид нар энэ ковидтой хэцүү үед энэхүү санхүүжилтийг хэрэгжүүлсэн. Энэ маань бас тодорхой үр дүнгүүд гарч байгаа.

Тийм учраас энийг өшөө бид нар сайжруулах ажлуудаа хийгээд судалгаа шинжилгээнүүдээ хийгээд тогтмол засаж сайжруулаад явж байна. Энэ дээр одоо яах вэ ЭМД-ын тогтолцоо нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжинэ гэдэг маань их том эргэлт хийгдсэн гэж үзэж байгаа. Энэ маань өөрөө төр, хувийн хэвшил бол ялгаа байхгүй. Нэг түвшний бүх иргэн, иргэнд одоо эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад ямар нэгэн чирэгдэл байхгүй, хүртээмжтэй санхүүгийн дарамтгүй байх энэ бодлогыг баримталж бид нар энэ хүү шинэчлэлийн ажил үр дүнтэй явагдаж байгаа. Мэдээж одоо хуулийг хэрэгжүүлэхэд бас тодорхой хугацаа шаардлагатай учраас энэ маань одоо ингээд үргэлжлээд сайжруулалтаа хийгдээд явна гэдгийг бас хэлэх гэсэн юм.

С.Одонтуяа: 85.

В.Баярмаа: Би гишүүний 2 асуултад товчхон хариулья.

Гадаад эмчилгээний талаар тоон статистикаар 2017-2021 оны хооронд 389 иргэн бол ЭМЯ-нд гадаад улсад эмчилгээнд явсан тухайгаа мэдүүлж, бас санхүүгийн дэмжлэг хүссэн ийм юу өгсөн байна. Үүнээс 305 иргэн бол эрхтэн шилжүүлэн суулгасан байна. Жилдээ ер нь дунджаар бол 100-120 иргэн бол ЭМЯ-нд сайдын тушаал батлагдсан энэ Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчний жагсаалтаар санхүүгийн дэмжлэг хүссэн өргөдлийг өгч шийдвэрлүүлдэг байна. Гадаад эмчилгээний хувьд бол товч мэдээлэхэд ийм байна.

Хоёр дахь нь энэ эд эс эрхтэн шилжүүлэн суулгах. Манай улсын хувьд бол бөөр эдлэг, ясны чөмөг, эвэрлэг шөрмөс шилжүүлэн суулгах мэс заслууд бол хийгдэж байгаа. Үүнээс дараагаар бол одоо бас нойр булчирхай шилжүүлэн суулгах төсөл бол эхэлсэн явж байгаа. Энэ эд эс эрхтэн шилжүүлэн суулгахдаа ЭМЯ бодлоготойгоор нэгдүгээрт, хууль эрх зүйн хувьд бол энэ онд чуулганд өргөн баригдахаар энэ Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль бол өөрөө тусдаа хууль болон батлагдахаар боловсруулагдаж бас Улсын Их Хурлын гишүүдийн дэмжлэгтэйгээр одоо чуулганд өргөн баригдахаар явагдаж төлөвлөгдсөн явж байна.

Таны асуусан энэ амьгүй донороос буюу энэ дэлхий нийтэд яг энэ эрхтэн шилжүүлэн суулгах дээр асуудал байдаг. Донор, донор дотроо амьгүй донороос шилжүүлэн суулгалтын хувийг бол өсгөх ёстой байдаг. Манай дээр энэ амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгаж байгаа донор эмнэлгүүд гэж 4 эмнэлэг байдаг. Үүний тоог энэ жил бид бүхэн дахиад хөдөө орон нутгуудаас донорын төвүүдийг нэмж гэрээ байгуулан

оруулах байдлаар ингээд жил болгон энэ донор эмнэлгүүдийн тоог нэмэгдүүлэх, эрхтэн шилжүүлэн суулгагчдын тоог нэмэгдүүлэх байдлаар ажиллахаар ажиллаж байна.

Гадаад эмчилгээн дээр бол 2017-2021 оны хооронд нийт 389 иргэн бол ЭМЯ-нд бол энэ Монголд эмчлэгдэх оношлогдох боломжгүй өвчний жагсаалтын дагуу өргөдөл гаргаж шийдвэрлүүлсэн байна. Үүний 350 иргэн нь бол дандаа энэ эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлээр гадаад улс руу явсан байгаа. Сайдын багц дээр бол энэ 500 сая төгрөг төсөвлөгдсөн. Энэ гадаадад явж байгаа иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх дээр бол үзүүлдэг. Энэний зарцуулалт бол жилдээ бүтэн, ерөнхийдөө бүтэн нь дандаа зарцуулагдаад явдаг. Ийм байдалтай байгаа.

С.Одонтуяа: Сайд нэмж хариулъя. 81.

С.Энхболд: Бид нар, ялангуяа энэ Монголд эмчлэгдэх боломжгүй 26 онош байдаг. Бид нар 2021 оны хөрөнгө оруулалтаар бид нар бас энд бодлогын томоохон хөрөнгө оруулалтуудыг хийж, энэ 26 оношоос 6 оношийг нь бол Монголдоо хийдэг болсон байгаа. Энэ 2 жилийн дотор нэвтэрсэн гэсэн үг. Мэдээж нэг өвчний оношийг бас нэвтрүүлэхийн тулд өөрийн хоорондоо хийдэг болохын тулд маш олон хүний хүч хөдөлмөр байдаг. Багаар ажиллаж байж, мөн бас бодлогоор дэмжиж байж энэ маань хийгддэг.

Тийм учраас одоо үүний нэг жишээ нь бол, ялангуяа донороос үүдэл эс шилжүүлэн суулгах хагалгааг бол бид нар хийсэн. Энэ дээр бол бид нар бодлогын түвшинд одоо 1.4 тэрбум төгрөгийг төсөвлөж байж хөрөнгө оруулалтуудыг хийж байж энэ

хагалгаа маань бас сая амжилттай хийгдсэн. Одоо ингээд ирэх жилээс бид нар ялангуяа хүүхдэд хийхийг бол төлөвлөж байна. Энэ мэтчилэн мэдээж одоо бүх оношийг бол аль болох тодорхой хэмжээний цаг хугацаа хэрэгтэй. Бас хөрөнгө оруулалтууд шаардлагатай.

С.Одонтуяа: Баттөмөр гишүүн тодруулъя, 1 минут.

Б.Баттөмөр: Энэ мэргэжлийн сайд ажиллаж байгаа бол бас ололттой гэж ингэж харж байгаа. Бас урд нь янз бүрийн одоо мэргэжлийн хүмүүс ажиллаж байсан. Би энэ асуултуудаас дутуу хариулаад байна. Ялангуяа энэ цус ойртолт хариулаа ч та нар. Энэ Монголын одоо тэр үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал. Ургийг гажиг өөрөөр хэлбэл эрт илрүүлэх чиглэлээр та нар ямар ажил хийж байна аа гэсэн ийм юм.

Гурав дахь нь тэр нөгөө нэг эмийн ургамалтай холбоотой. Ийм 3 асуултад би хариулт авч чадсангүй хариулаач.

С.Одонтуяа: 87 дугаар микрофон нээе.

Б.Буянтогтох: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Буянтогтох.

Цус ойртолтын асуудал бол үнэхээр үндэсний аюулгүй байдлын чухал асуудлуудын нэг. Гэсэн хэдий ч одоо цус ойртолтыг илрүүлэх асуудал бас нэлээн технологи шаардсан, зардал шаардсан ийм одоо судалгааны ажлаар илэрдэг ийм онцлогтой.

Монгол Улсын үндэсний хэмжээнд бол Энхмаа, Батсуурь гээд 2

доктор яг энэ чиглэлээр бол ажилладаг. Өөрийнхөө одоо гаргасан судалгаануудыг бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд бол хүргүүлсэн.

Тэгээд би танд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн 2017 оны одоо тайлангаас авсан мэдээлэл хүргэе. Тэгэхээр тухайн онд тайлагнасан оноор бол Монгол Улсад бол оюуны хомсдол цус ойртолт нь бол яг гадаад илрэл нь бол оюуны хомсдлоор түгмэл илэрдэг. Тэгэхээр энэ Монгол Улсад оюуны хомсолтой нийт одоо 19808 хүн байгаа гэсэн ийм судалгаа хийгдсэн. Эдгээрийн бол 50 хувь нь бол цус ойртолтоо болоод шалтгаалдаг байна.

С.Одонтуяа: Гишүүдийн асуултад яг дуустал хариулчих. Өөр одоо хэддүгээр микрофон нэмж хариулах вэ? 87.

С.Энхболд: Цус ойртолтын талаар нэмэлт мэдээлэл явъя. Тэгэхээр одоо бол Их Хурал дээр бид нар Эрүүл мэндийн яамны сайдын тушаалаар Хүний генетикийн тухай хууль үзэл баримтлалын түвшиндээ явж байгаа. Тэгэхээр яг энэ хүрээнд бол энэ Монгол хүний удмын сангийн асуудал, Монгол хүний генийн банкний асуудал гэх зэрэг, энэ цус соролттой холбоотой энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой энэ асуудлууд бүгдээрээ хуулийн хүрээнд шийдэгдэхээр ингээд үзэл баримтлал дээр тусгаад явж байгаа. Энэ бол цаашидаа яг энэ дээр бол нарийн ийм үндэсний хэмжээний лавлагаа лабораторийг байгуулах асуудал бол хамгийн чухал асуудал болж байгаа. Бас энэ банкны мэдээллийг хамгаалах, хадгалах асуудал бас энэ хуулийн хүрээнд үзэл баримтлалд нь ороод шийдэгдээд явахаар төлөвлөгдөөд явж байгаа.

С.Одонтуяа: Одоо Хасарын Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Сайн байна уу? Энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны түрүүнд Эх нялхсын эрүүл мэндийн төвийн бүтээн байгуулалтын ажлыг амжилттай сайн хэрэгжүүлж байгаа. Эрүүл мэндийн яамны хамт олонд бас талархал илэрхийлье. Миний холбогдолтой асуух гэж байгаа асуулт бол ЭМД-тай холбоотой 3 асуулт асуух гэсэн юм. Одоо ингээд тойргоор иргэдтэйгээ хороодоор уулзалтууд хийгээд явж байна. Энэ жил одоо тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлсэн. Бусад тэтгэврийг 15 хувиар нэмэгдүүлсэн. Гэхдээ эргээд хүнс, эмийн үнэ нэмэгдчихээд байна гэдэг асуудлыг тавьж байна.

Эмийн үнэ нэмэгдсэн гэдэг нэгдүгээр асуулт. Яагаад нэмэгдэж байна? Энийг зохицуулах боломж юу байна?

Хоёр дугаар асуулт хөнгөлөлттэй холбоотой асуудал ярьж байна. Одоо зарим эмүүд нь хуучин жороороо одоо хөнгөлөлттэй авдаг байсан бол одоо хөнгөлөлттэй авах боломжгүй болчихоод байна аа? Энийг бол манай хороодын нэлээд олон ахмадуудаас бол тэгээд энэ 700 гаруй төрөл эрүүл мэндийн хөнгөлөлттэй даатгалтай байсан бол одоо 500 эм хөнгөлөлттэй олгож байна гэсэн ийм яриа гарч байна. Тэгэхээр энэ ямар үндэслэлээр яагаад хасагдсаныг мэдмээр байна.

Гуравт энэ жор болон чанартай холбоотой асуултыг асуух гэсэн юм.

Одоо жорыг бол өрхийн эмнэлэг дээр бичиж байгаа гэсэн, зарим нь болохоор одоо нэгдсэн эмнэлэг рүү шилжиж байгаа гэсэн бас яриа гараад

байх юм. Тэгээд энийг өрхийн эмнэлэг дээр нэг хэвээрээ үлдсэн эсэхийг нь л тодруулчихмаар байна. Чанартай холбоотой асуудлыг одоо сая тэр эмийн чанарыг шалгах ажлын хэсэг яваад байсан. Тэгээд тэр чанартай холбоотой асуудлаар ямар нэгэн тийм шинэ өөрчлөлт гарсан эсэх, одоо энэ тал дээр ямар шийдэлтэй байгаа юм? Тэгээд манай дээр чинь дандаа орц дутуу эмүүд орж ирдэг гээд байсан. Энийг хяналт шалгалтыг хэрхэн яаж хэрэгжүүлж байгаа тал дээр нэг асууцчихмаар байна.

Дараагийн асуулт болохоор энэ өрхийн эмнэлэг дээр өрхийн эмнэлэг бол одоо хамгийн анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага. Тэгэхээр энэ өрхийн эмнэлгүүдийг лабораторитой холбох энэ ажлууд ер нь явагдаж байгаа юу? Тэгээд ингээд шинжилгээ өгөхөөр ингээд төв эмнэлэг рүү явах юм уу, нэгдсэн эмнэлэг рүү явуулах тэндээ очер үүсгэдэг түгжрэл бий болгох гээд энэ асуудлууд байгаад байгаа байхгүй юу?

Тэгээд анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, анхан шатны тэр шинжилгээ авах энэ тогтолцоог ер нь бий болгох тал дээр ямар ажлууд хийж байгаа вэ гэдэг эхний ээлжид асуулт асуучихаад, дараа нь тодруулга авъя.

С.Одонтуяа: Олон асуулт асуулаа. Товчхон хариулаарай. 87 дугаар микрофонд хариулъя.

Б.Буянтогтох: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. ЭМЯ, Буянтогтох. Эмийн үнийн асуудал бол байгаа. Бид нар сая 10 сард бас эмийн ханган нийлүүлэх байгууллагууд болон тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллагуудтайгаа эрүүл мэндийн

технологи гээд үзэсгэлэн зохион байгуулсан. Энэ хүрээнд бас энэ асуудлууд бас яригдсан байгаа. Тэгэхээр одоо бол өмнөх онтой харьцуулахад бол зүгээр дунджаар бүх бүтээгдэхүүнийг дундажлаад аваад үзэх юм бол 45 хувийн өсөлттэй байна гэсэн мэдээлэл тухайн үед бол гарсан.

Тэгэхээр нөлөөлж байгаа хүчин зүйл бол нэгдүгээрт бол валютын үнийн өсөлт нэгдүгээрт маш том нөлөө үзүүлж байна.

Хоёрдугаарт бол энэ тээвэр ложистикийн үйл ажиллагааны зардал бас нэмэгдсэнтэй холбоотой.

Гуравдугаарт тухайн одоо импортоор оруулж ирж байгаа улстай түүхий эдийн тухайн бүтээгдэхүүний түүхий эдийн үнийн өсөлттэй холбоотой гэсэн ийм түгээмэл 3 хүчин зүйлээс хамаарч үнийн өсөлт болж байна гэсэн ийм асуудал ярьж байгаа юм. Эрүүл мэндийн яамнаас ямар арга хэмжээ авав гэхээр бид бас энэ ханган нийлүүлэх байгууллагууд дээр репо зээлийн асуудлуудыг бүгдийг нь нэгтгээд бас Монголбанк руу явуулсан. Тэрэн дээр бол тодорхой хэмжээнд банкттайгаа тухайн ханган нийлүүлэх байгууллагууд бол бүгдээрээ зээлийнхээ нөхцөлийг судлуулаад зээл олгох арга хэмжээ авч байгаа. Мөн гадагшаа гарах валютын шилжүүлэх валют дээр бол хязгаарлалттай байсныг Монголбанкттай хамтраад бас энэ хязгаарлалтыг бууруулах чиглэл дээр бас ажиллаад ингээд явж байгаа.

Гэхдээ үнийн өсөлт бол гарцаа байхгүй бол энэ дээрх одоо давагдашгүй хүчин зүйлүүдтэй холбоотой гэж харж байгаа. Хөнгөлөлттэй эмийн асуудал бол сая 9 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Хэрэгжиж эхлэхдээ тухайн эмийн

үйлчлэлээсээ хамааруулаад эмчийн хяналт зайлиггүй байх ёстой гэх зэрэг шалтгаануудын улмаас зайлиггүй энэ 4 зэрэглэлд бол хувааж өгсөн. Өмнөх тогтоолоос ялгаатай зүйл нь бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч нэр, хөнгөлөлттэй эмийг бичих боломжтой боловч зарим нэгэн эмийг тухайн эмчилгээний үр дүнг зайлиггүй төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт хянах шаардлагатай гэдэг үүднээс зарим эмийг бол энэ дээшээ лавлагаа шатны эмнэлгүүдэд бичүүлдэгтэй холбоотой ийм иргэдийн дунд гарсан асуудлууд бол гарсан.

Дараачийн нэг асуудал бол уртаашаа аваад үзэх юм бол 70 хувиас 30 хувь руу хөнгөлөлтийг бууруулсан 23 эм л байгаа юм. Гэхдээ энэ нь бол олон улсын эмчилгээний удирдамжууд холимог найрлагатай эм тухайн олон улсын удирдамж дээр орсон, тухайн эмийнх нь үйлчилгээний нотолгоо нь хангалттай биш байсан учраас одоо өөр сонголт ийм байгаа гэдэг үүднээс одоо 23 нэр төрлийн эмэн дээр бид нар хөнгөлөлтийг нь бол 70 хувиас 30 хувь бууруулсан ийм зохицуулалтыг бол хийж өгсөн байгаа. Эмийн чанарын асуудал дээр бол Их Хурал дээр Их Хурлын гишүүн Учрал гишүүний ахалсан баг ажиллаж байгаа. Бид бол энэ хүрээнд одоо Түр хорооны гишүүдээс тавьж байгаа гол шийдэх ёстой зүйл бол эмийн чанар гэдэг зүйл бол чанартай эмийг оруулж ирэх асуудал ганцхан байдаггүй юм байна.

Энэ эцсийн хэрэглэгч хүртэл 7-8 шатанд эмийн чанар алдагдах ийм эрсдэлтэй байдаг учраас энэ эрсдэлийг одоо байхгүй болгохын тулд гарцаагүй шийдэх ёстой нэг зүйл бол энэ лабораторийн асуудлыг шийдэх асуудал байдаг юм байна гээд. Бид бол ЭМЯ он гарснаас хойш яг энэ лабораторийн хүчин чадамжийг

сайжруулах үүднээс судалгаа хийгдсэн. 5.4 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн хэрэгцээ байгаа гэдэг судалгааг бол Сангийн яаманд хүрсэн. Гэсэн ч энэ жил бол шинээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхгүй гэсэнтэй холбоотой бол хасагдсан байгаа. Гэхдээ энэ асуудлыг бол дахиад л цаашаа одоо өөр эх сурвалжаас санхүүжилтийг нь олж шийдэх асуудал бол тулгамдаж байгаа асуудлын нэг байгаа.

Энэ хүрээнд бид нар бас сая Английн парламентын гишүүд ирэхэд бас санал тавьсан. Одоо энийг сайжруулах чиглэлээр хөнгөлөлттэй ийм зээл олгох асуудал бас төсөл хөтөлбөрийг бол санал тавьсан. Тэдний зүгээс бол боломжтой гэсэн хариулт өгсөн. Өрхийн эрүүл мэндийн төвийн лабораторийн асуудал энэ бол нэг ийм л асуудал байгаа юм. Ер нь бол Монгол Улсад анхан болон лавлагаа гээд 2 шатны тусламж үйлчилгээ үзүүлэх ийм 2 төрлийн байгууллага байдаг. Гэхдээ давхардал үүсгэчихвэл даатгалын сангийн хүртээмж гэдэг зүйл бол байхгүй болно. Бас даатгалын сандаа багтахгүй ийм асуудал үүсдэг учраас анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх дээр бид нар заавал нөгөө энэ шатанд үзүүлэх тусламж үйлчилгээг нь багцаар нь хязгаарлаж өгдөг.

Хэрвээ анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх гэж байгаа байгууллага дээр лавлагаа шатлалын лабораторийн тусламж үйлчилгээ үзүүлээд эхлэх юм бол нэгдүгээрт шинжилгээний одоо замбараагүй байдал бий болно.

Хоёрдугаарт, даатгалын сангийн үр өгөөжтэй байдал дээр томоохон эрсдэл учрах учраас энэ дээр тодорхой хэмжээний бол

хязгаарлалтыг тавьж өгсөн. Гэсэн хэдий ч Өрхийн эрүүл мэндийн төв болон сумын эмнэлгийн төвд бол 05 дугаар тогтоолоор нийтдээ 50 төрлийн шинжилгээг үзүүлэх ийм бололцоог нь бол бас нээж өгсөн байж байгаа. Яг лавлагаа шатанд хийдэг шинжилгээг өрх анхан шатан дээр хийх бол.

С.Одонтуяа: Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулъя, 1 минут.

Х.Ганхуяг: Тодруулчихъя. Энэ цахим шилжихтэй холбоотойгоор ЭМЯ дээр 3 удаа программ суулгасан асуудал яригддаг. Тэрнээсээ болоод өрхийн эмнэлгүүдээр ч тэр, бусад эмнэлгүүдэд ч гэсэн хүндрэл нэлээдгүй гарсан байна лээ. Тэгээд энэ гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлсэн байдаг 45 сая долларын асуудал шүү дээ энэ чинь бол бас бага мөнгө биш. Тэгэхээр энэ тал дээр ахиц гарсан уу? Тэгээд ерөөсөө л нэг байж байгаад л одоо шинэчилж байна гээд л одоо шинэ программа суулгахгүй бол санхүүжилтийг чинь өгөхгүй гээд л шахаад л явдаг. Тэгээд нөгөөдөх нь олигтой ажилласан ч юм байдаггүй нэг ийм асуудал үүсээд байгаа юм. Тэгээд энэ дээр одоо хамгийн сүүлийн үеийн мэдээлэл нэг авчихмаар байна.

Гуравт болохоор нөгөө ЭМД бол энэ бол хуримтлалын сан бий шүү дээ тийм ээ. Тэгэхээр яах вэ одоо байгаа хуримтлал нь хүртээмж нь, ер нь бид нарын 2020 оны 8 сард баталсан тэр эрүүл мэндийн багц хуультай холбогдолтойгоор яг санхүүжилтүүдээ хангалттай өгч.

С.Одонтуяа: Эрүүл мэндийн сайд Энхболд хариулъя.

С.Энхболд: Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Энэ эрүүл мэндийн салбарт 2 удаа энэ цахимын төсөл хөтөлбөр хэрэгжсэн. Өмнөх нь бол БНХАУ-ын и хэлп гээд систем байгаа. Энэ бол улсын, ялангуяа лавлагаа шатлалын 48 эмнэлэгт бол ашигладаг ийм программ хангамж суугдсан.

Хоёрт 2016 оноос эхэлсэн энэ Дэлхийн банкны санхүүжилттэй 19.5 сая долларын санхүүжилттэй төсөл хэрэгжсэн. Энэ төсөл маань одоо яах вэ хэрэгжих хугацаа бол 2016 оноос эхэлж явсан байгаа процедурын хувьд. Энд тодорхой шалтгааны улмаас тендер зарлах, гэрээ байгуулах гээд ингэж явсаар байгаад 4 жилийг зарцуулчихсан. Яг албан ёсоор ажил нь бол 2021 оны 9 сарын 27-ны өдөр эхэлсэн. Энэ өөрөө барьцаа төлбөр, тухайн гүйцэтгэгч компанийн барьцаа төлбөр чөлөөлөгдсөн цагаас эхлэн энэхүү төсөл маань хэрэгжинэ гэсэн ийм.

С.Одонтуяа: Дуусгаад хариулчих Энхболд сайд.

С.Энхболд: Энэхүү төсөл маань одоогийн байдлаар хэвийн явагдаж байгаа. Бид нар одоо ялангуяа энэ эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа энэ маш олон төр болон хувийн хэвшлийн энэ компаниудын гучин хэдэн программ ашиглаж байгаа. Энийг ялангуяа бид нар нэг системд л оруулах гээд байгаа юм. Бүгд одоо нэг магистрал замын л тавьж өгч байгаа гэсэн үг. Энэ ажил маань одоо энэ ондоо багтааж бид нар дуусгана гэсэн төлөвлөлттэй. Ер нь гүйцэтгэгч компани бол ажлаа хийж байгаа. Анхан шатан дээр бид нар ялангуяа 535 байгууллага дээр и хостел гэдэг программыг бол явуулж байгаа. Энэ маань өөрөө хоорондоо өгөгдөл солилцдог болоод эхэлчихсэн байна. Энэ

бол ингээд ажлууд маань үе шаттай нэлээн хурдацтай явж байгаа. 2021 оны 9 сараас эхэлсэн гэхэд бас нэлээн эрчимтэй явагдаж байгаа. Яг албан ёсоор болгох хугацаа 2023 оны 4 сард дуусна.

Дэлхийн банк бол сая 9 сарын 30-нд энэ төсөл маань явахдаа бас 2 удаа сунгагдсан байдаг юм. Бид нар бас яг энэ сая есөн сарын 30-нд хугацаа дуусахаас өмнө Дэлхийн банк руу хүсэлт тавьсан. Тэгэхдээ бол одоогийн байдлаар энэ санхүүжилтийг нь бол зогсоосон. Тэгэхдээ ажил бол явдгаараа явж байгаа гэсэн үг.

Тэгэхээр бид нар ямар ч байсан энэ системийг бол бүрэн угсарч дуусна гэсэн үг. Тэгэхээр ямар ч эрүүл мэндийн салбар өөрөө нэгдсэн тийм системтэй болно. Энэ дээр энэ системийг угсарсны дараа харин хувийн хэвшилүүд маань өөрсдөө энэ системтэйгээ холбогдоод явах бүрэн бололцоо, боломж нь бүрдэнэ гэсэн үг. Даатгалын сан бол 2020 оны 8 сард хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн. 2021 оны 3 сараас эхлэн бид нар албан ёсоор улс орон даяар хэрэгжсэн. Одоогийн байдлаар 2021, 2022 онд бол даатгалын сангийн хүртээмжийг бол тодорхойлох боломжгүй байсан. Яагаад гэхээр ковидын эффект байсан учраас. Одоо нийтдээ бид нар 2021 оны ковидын тусламж үйлчилгээнд бол 564 тэрбум төгрөг зарцуулсан байдаг. 2022 онд бол бас 130, 140-өөд тэрбум төгрөгийг бас ковидын зөвхөн тусламж үйлчилгээнд зарцуулсан байгаа. Тэгэхээр 2023 онд одоо ямар нэгэн бид нар ковидын эффект байхгүй ямар нэгэн нийтийн эрүүл мэндийг хамарсан ийм ноцтой байдал үүсэхгүй бол яг жинхэнэ даатгалын сангийн хязгаар ямар байх

ёстой гэдэг нь жинхэнэ бодит юм гарч ирнэ гэсэн үг.

Энэ салбарын шинэчлэлийн ажил бол ингээд үе шаттай хийгдээд сайжруулалт нь хийгдээд явж байгаа л гэсэн үг. Тэгэхээр яг бодит юу бол одоо даатгалын сангийн хүртээмж яг цаад хязгаар нь 2023 онд бас илүү бодитой гарч ирэх боломж бололцоо гарч ирнэ гэсэн үг.

С.Одонтуяа: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан үг хэлнэ ээ.

Б.Баярсайхан: Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар салбарын сайдад асуулга тавьж, өнөөдөр тодорхой хэмжээнд олон гишүүд асуулт тавьж, энэ эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн салбарын үндсэн чиг үүрэг болсон нийгмийн эрүүл мэндийг сайжруулахад ямар үр дүнтэй ажлууд хийгдэж байгаа юм, ямархуу янзтай явж байгаа юм гэдэг дээр бас нэлээн сайн мэдээлэл одоо авсан болов уу? Дүр зураг харагдаж байгаа болов уу гэж бодож байна.

Өнөөдөр нийгмийн эрүүл мэнд, нийтийн эрүүл мэнд гэдэг үг нь хүртэл зөрчилдөөнтэй. Орчуулахдаа 2 өөр янзаар явчихсан. Хуульдаа болохоор нийгмийн эрүүл мэнд гэж явдаг, энэ *humens public health* гээд тэгэхээр нийтийн эрүүл мэнд гээд ингээд 2 янзаар өөрчлөөд ингээд явчихсан. Энэ асуудлаа хүртэл та бүхэн минь цэгцлээд өгөөч ээ.

Өнөөдөр Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн амын нас баралтын 77 хувь буюу хавдраар нас барж байгаа халдварт бус өвчнөөр нас

барж байгаа нийт 10 хүний 8-ыг нь бид нар аврах боломжтой. Амь насыг нь аврах боломжтой. Урьдчилан сэргийлэх боломжтой байгаа. Дахин хэлье, нас барж байгаа 10 хүн тутмын 8-ыг нь бид нар амьд сэрүүн байлгах боломжтой байгаад байна.

Сүүлийн 20 жилд хавдраас шалтгаалсан нас баралт тасралтгүй өссөөр өнөөдөр бид нар дэлхийд хавдраараа 2 дугаар байранд эрэмбэлэгдэж байгаа. Бид ковидын үед Монгол Улсын Засгийн бас тодорхой үр дүнтэй сайн ажиллаж, бусад улс оронтой харьцуулахад бид нар арай бага. Монгол Улсын хэмжээнд 2000 гаруй хүнээ бид нар, энэ дэлхий нийтийн цар тахалд бид нар алдсан. Гэтэл жил болгон бид нар 4000-аас бараг 5000 шахуу хүнийг энэ хавдрын өвчлөлөөр нас алдаж байна. Жишээлбэл 2021 онд бид 4251 хүнээ алдсан. Энийг энэ тоог харах юм бол бүтэн 1-2 сумын хүн амтай тэнцэх ийм одоо хүмүүсээ бид хавдраар алдаж явуулж байна. Энэ санаа зовох асуудал биш гэж үү? Санаа зовохгүй байх асуудал юм уу? Халдварт бус өвчлөлийг үүсгээд байгаа хамгийн том хүчин зүйл нь бол одоо таргалалт гэдгийг та бүхэн өөрсдөө тайлан дээрээ дурдаж байна.

Монгол Улсын нийт бүс нутгийн түвшинд илүүдэл жин ба таргалалтын таргалалт насанд хүрсэн 2 хүн тутмын нэг, 3 хүүхэд тутмын нэг нь илүүдэл жин, таргалалттай байгаа нь өнөөдөр гамшигийн хэмжээнд хүрч, нийгмийн эрүүл мэндэд тулгарч болзошгүй хамгийн том эрсдэл болоод байна. Монгол Улсын хөдөлмөрийн чадвартай хүн амын 55 хувь нь илүүдэл жинтэй байгаа. Эдгээрийн 19 хувь нь бүр таргалалт гэдэг өвчний оноштой байгаа. Тэгээд ийм байхад бид нар яаж хүн амынхаа дундаж наслалтыг яаж

нэмэгдүүлэх юм бэ? Ялангуяа бид нар эрчүүдээ эрэгтэйчүүдийнхээ дундаж наслалтыг өсгөж, амьдралын чанарыг яаж одоо сайжруулах юм бэ гэдэг асуудал өнөөдөр хамгийн гол чухал асуудал болоод байна.

Өнөөдөр айл болгонд магадгүй нэг хавдартай хүн. Хамаатан садан, найз нөхдийн дунд хавдартай хүмүүс байна. Ард иргэд туйлдаж байна. Ийм байхад бид нар өвчлөлийг архагшсан, хожуу үед нь өртөг өндөртэй оношлоод эмчлээд, үүнд эрүүл мэндийн салбарын төсвийн дал гаруй хувийг зарцуулж байгаа нь бид урвуу тогтолцоотой яваад байгаа гэдгийг ингээд харуулаад байна.

Өнөөдрийн манай эрүүл мэндийн тогтолцоо нь урьдчилан сэргийлэх биш, өвдсөн хойно нь эмчилдэг ийм урвуу тогтолцоотой байгаад байна. Үүнд улс хамаг төсвөө барж байна. Хамаг хүчээ барж байна. Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчид хүчээ барж байна. Хүмүүс өөрсдийнхөө амь насыг алдаж байна. Тэгээд бид өвдсөн хойно нь биш, өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлнэ гээд мэдээд байгаа мөртөө энэ ажил дээр өнөөдөр харамсалтай нь төдийлөн үр дүн гарахгүй байгаад байна.

Хэрвээ бид нийгмийн эрүүл мэндээ сайжруулах энэ 2 үндсэн чиг үүргийнхээ нэгийг нь илүү үр дүнтэй болгож, энэ салбарт ийм реформ хийж чадах юм бол өнөөдөр Монголын эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, ажилтнуудын маань ачаалал буурч, тэд нар маань арай илүү нөхцөлд одоо ажиллах ийм боломж бүрдэнэ. Монгол Улсын 2021-2025 оны хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог

үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ гэж заасан. Уг арга хэмжээний хэрэгжилтийг 2021 онд та бүхэн маань өөрсдийнхөө ажлыг 100 хувь гээд үнэлээд ороод ирсэн. Энэ ажилд 18.6 тэрбум төгрөг зарцуулагдсан байгаа. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж.

С.Одонтуяа: Асуулга тавьсан гишүүний минутыг нэмж өгье.

Б.Баярсайхан: 5 минут хэрэгтэй байгаа. Үзлэг оношилгоонд хамрагдах, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж Монгол Улсын Засгийн газар зорьж байгаа боловч 2021 оны байдлаар энэ ажлыг 70 хувьтай үр дүнд хүрсэн гээд та бүхэн маань тодорхойлчихсон байгаа. Гэтэл энэ амьдрал дээр хэрэгжиж байна уу, үнэхээр 70 хувьтай хэрэгжсэн юм уу гэдэг асуудал чинь өнөөдөр эргэлзээтэй байгаад байна аа. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд та бүхний байгуулсан дэмжих төв, салбарын бодлого нь хүн амын дунд хоол, шим тэжээлийн боловсрол олгож, амьдралын зөв зан үйлийг төлөвшүүлэх нь хамгийн өртөг багатай, үр дүнтэй арга юм гэдгийг та бүхэн бүхэн, бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Өнөөдөр эрүүл байхын тулд зарцуулж байгаа нэг төгрөг өвчтэй болсон хойноо зарцуулж байгаа 20 төгрөгтэй тэнцэнэ гэдгийг ДЭМБ тодорхойлчихсон байгаад байна.

Амьдралын хэв маягаа өөрчилж, зохистой хооллож, биеийн жингээ тогтмол хэмжээнд байлгах нь зүрх

судасны өвчлөл, нас баралтын 80 хувь, чихрийн шижинг 90 хувь хүртэл бууруулах боломжтойг эрдэмтэд яриад хэлээд тогтоочоод байна. Зохистой хооллоод биеийн жингээ хэвийн хэмжээнд барьж, амьдралынхаа туршид идэвхтэй хөдөлгөөнийг эрхэмлэх юм бол хорт хавдрын тохиолдлыг 30 хувиар бууруулж болно гэдгийг бас тогтоочоод байна. Тэгээд бид хамгаалж чадах, урьдчилан сэргийлж болох энэ өвчлөл рүү анхаарч өвчилсний дараа биш өвдөхөөс нь өмнө хамгаалж чаддаг ийм эрүүл мэндийн тогтолцоог Монгол Улсад хэрэгжүүлмээр байна. Сүүлийн жилүүдэд Монголын иргэд спортоор хичээллэж байгаа. Мөн одоо нутришн буюу одоо шим тэжээлтэй хоолыг эрхэмлэж байгаа, спортоор хичээллэж байгаа иргэд маань өөрөөр хэлбэл одоо хичээж эхэлж байгаа ийм сайхан үр дүн бол харагдаж байна. Энд юу дутагдаад байна гэхлээр салбарын үр дүнтэй менежмент дутагдаад байна. Та бүхний манлайлал дутагдаад байна.

Тийм учраас энэ дээрээ өөрчлөлт шинэчлэлт хийгээд өгөөч ээ. Монгол хүн, Монгол Улсын хамгийн үнэ цэнтэй үнэт баялаг юм бол Монгол Улс цаашидаа хүчирхэг үндэстэн болж үнэхээр одоо тогтохын тулд өнөөдөр Монгол иргэн маань эрүүл байх хэрэгтэй байгаад байна.

Тийм учраас энэ Монгол Улсын Үндсэн чиглэлд зорьж байгаа энэ зорилт Монгол Улсын энэ Засгийн газрын зорьсон зорилт, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг 2022 онд эрүүл мэндийн салбар үр дүнтэй хэрэгжүүлж, иргэдэд эрүүл мэндийн боловсролыг олгож, иргэдийг зөв зохистой хоол, зөв зохистой амьдралын хэв маяг руу та бүхэн маань одоо чиглүүлэх энэ үндсэн үүргээ

хэрэгжүүлээч ээ, манлайлж ажиллаач ээ. Эрүүл мэндийн салбарт реформ шинэчлэл хийгээч ээ, хүмүүсээ энэ цаг бусаар амь насаа алдаж байгаа энэ аюулаас та бүхэн авраач ээ, хамгаалаач гэдгийг өнөөдөр та бүхэнд онцлон анхааруулахыг хүсэж байна.

Тэгээд 2022 оны энэ төсвийг бид нар бас дахиад л эрүүл мэндийн салбарын төсвийг бид нар хангалттай баталж өгсөн. Энэ төсвийг үр дүнтэй зарцуулж өөрсдийнхөө одоо эрхэлсэн ажилд хариуцлагатай хандаж, иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалахад чин сэтгэлээсээ та бүхнийг үр дүнтэй ажиллаасай гэж хүсэж байна.

Маш их баярлалаа баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Балжинямын Баярсайханаас Эрүүл мэндийн сайдад хандан тавьсан асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонслоо.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19.1- Улсын Их Хурлын дарга, хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хороог хэрэв тухайн төсөлд хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол холбогдох болон бусад Байнгын хороог зөвлөлтэй зөвшилцөн тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг танилцуулъя.

1.Нөхөх олговор олгох тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адьшаа, Чимэдийн Хүрэлбаатар нар 2022 оны 11 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсан байна аа. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Одоо даргын дэргэдэх зөвлөл хуралдана.

